



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2022 • № 62

Б.БАЯРДАВАА:
ИНФЛЯЦЫГ ДУНД
ХУГАЦААНД 6+/-2 ХУВИЙН
ЗОРИЛТЫН ОРЧИМД
ТОГТВОРЖУУЛАХ
МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ
ҮРГЭЛЖЛҮҮЛЭН
ХЭРЭГЖҮҮЛНЭ

JEROME POWELL: МӨНГӨНИЙ
БОДЛОГО, ҮНИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

**Бодлогын хүүг нэмэгдүүлэх, бодлогын хүүний коридорыг шинэчлэн тогтоох,
банкуудын гадаад зах зээлээс шинээр татсан зарим эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох
эх үүсвэрээс хасаж тооцох тухай**

Дугаар: 2022/04

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 9 дүгээр сарын 16, 20-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

Бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэх;

Бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +2, -2 нэгж хувийн өргөнтэй болгох;

Банкуудын 360 хоног ба түүнээс дээш хугацаагаар гадаад зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох шийдвэр гаргалаа.

Жилийн инфляц 2022 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 14.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 14.8 хувьтай гарав. Инфляцад гадаад хүчин зүйлс импортын барааны үнээр дамжин голлон нөлөөлж, нийт инфляцын дийлэнхийг бүрдүүлж байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөө ирэх улирлуудад саарч, инфляц буурах хүлээлттэй байна.

Эдийн засгийн өсөлт эхний хагас жилд харьцангуй өндөр гарлаа. Хилийн хязгаарлалт тодорхой хэмжээнд суларсан хэдий ч уул уурхай, тээврийн салбарт үзүүлэх сөрөг нөлөө үргэлжилж байна. Худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар болон хөдөө аж ахуйн салбар зэрэг уул уурхайн бус салбарын өсөлт 2022 оны 2 дугаар улиралд эрчимжиж, энэ оны эхний хагас жилд цар тахлын

өмнөх буюу 2019 оны мөн үеийн түвшнээс давлаа. Өрхийн хэрэглээ сүүлийн 3 улирал дараалан өсөж, дотоод эрэлтийг нэмэгдүүлж байна. Энэ онд уул уурхайн бус салбарын идэвхжил үргэлжлэн нэмэгдэж эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэхээр байна.

Банкны системийн эх үүсвэрийн долларжилт нэмэгдэж, гадаад зах зээлийн суурь хүү өсч байгаа зэрэг нь төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгов. Иймд Мөнгөний бодлогын хороо инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах, төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын хүүг өсгөх, хүүний коридорыг цар тахлын өмнөх түвшинд хүргэж, өргөн болгох болон банкуудын гадаад зах зээлээс татсан зарим эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасах багц шийдвэрийг гаргав. Бодлогын хүүг нэмэгдүүлэх нь инфляцыг зорилтот түвшин рүү буцааж авчрахад хувь нэмэр оруулахаас гадна эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангах бодлоготой нийцтэй юм.

Цаашид мөнгөний бодлогын төлөвийг үргэлжлүүлэн хатууруулах эсэх нь гадаад, дотоод эдийн засгийн орчинд гарах өөрчлөлт болон инфляц, эдийн засгийн төлөв хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарна. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо инфляц зорилтот түвшинд тогтворжих хүртэл шаардлагатай бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ.

Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

“THE NU”
ДУРСГАЛЫН ЗООС
ГАРГАЛАА



12

БАЙР СУУРЬ

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН ТАЛААР
2023 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ЗААЛТЫН ТАЛААР
ОРОЛЦОГЧ ТАЛУУД
ЮУ ХЭЛЭВ?



17

АСУУЛТ, ХАРИУЛТ

МОНГОЛБАНКНЫ
УДИРДЛАГУУДЫН
СЭТГҮҮЛЧДЭД ӨГСӨН
МЭДЭЭЛЛЭЭС



30

ДЭЛХИЙН
ҮЙЛ ЯВДАЛ

JACKSON HOLE
ЭДИЙН ЗАСГИЙН
БОДЛОГЫН
ЗӨВЛӨГӨӨН:
ЭДИЙН ЗАСГИЙН
БОЛОН БОДЛОГЫН
ХЯЗГААРЛАЛТУУДЫГ
ДАХИН ҮНЭЛЭХ НЬ



34

ЗОЧИН

МӨНГӨНИЙ БОДЛОГО,
ҮНИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ



35

МӨНГӨ УГААХ
ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ

“МӨНГӨ УГААХ,
ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРТЭЙ
БОЛЛОО”



38

СУДАЛГАА

ОРГАНИК
СЕРТИФИКАТЫН
ГАЗРЫН
ҮНЭ ЦЭНД ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨЛӨЛ



08

ЯРИЛЦЛАГА

ИНФЛЯЦЫГ ДУНД
ХУГАЦААНД
6+/-2 ХУВИЙН
ЗОРИЛТЫН
ОРЧИМД
ТОГТВОРЖУУЛАХ
МӨНГӨНИЙ
БОДЛОГЫГ
ҮРГЭЛЖЛҮҮЛЭН
ХЭРЭГЖҮҮЛНЭ

“THE HU” ДУРСГАЛЫН ЗООС ГАРГАЛАА

2022/07/07



Монголбанкнаас дэлхийд “Хүннү” рок урсгалыг бий болгосон “Чингис хаан” одонт “The Hu” хамтлагийн амжилтад зориулж 3 цуврал дурсгалын мөнгөн зоос гаргалаа. Эдгээр зоосыг сүүлийн үеийн smartminting технологиор урлаж, хэсэгчлэн алтаар бүржээ. Дурсгалын зооснуудад Хүннү гүрэн мөн хамтлагийн лого, хамтлагийн гишүүдийг дүрсэлжээ. Зоос тус бүр нь 2 унц 50 мм, 3 унц 65 мм -ийн диаметртай юм.

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД ТОХИРУУЛГА ХИЙВ

2022/07/08



КОВИД-19 цар тахлын улмаас эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд орж, авсан зээл нь хэвийнээс бусад ангилалд орсон 50 мянга гаруй иргэн, ААН-ийн мэдээллийг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд харагдуулахгүй байх тохируулгыг хийв. Мөн Монголбанкны Зээлийн мэдээллийн санд үүрэн холбооны үйлчилгээ, үүрэн холбооны оператор компаниудын гурвалсан үйлчилгээний (IPTV, интернэт, суурин утас) төлбөрийн мэдээлэл нийлүүлэхийг зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр боллоо.

МОНГОЛБАНК УНГАРЫН ТӨВ БАНКТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

2022/07/19



Монголбанкны урилгаар Унгар улсын төв банкны /Magyar Nemzeti Bank/ Дэд ерөнхийлөгч Михали Патай тэргүүтэй зочид 2022 оны 07 сарын 17-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо ажлын айлчлал хийв. Айлчлалын хүрээнд талууд Хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Санамж бичгээр хоёр тал ногоон санхүүжилт, төв банкны цахим мөнгө, олон нийтийн санхүүгийн боловсрол, төлбөрийн системийн чиглэлд хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, харилцаагаа улам гүнзгийрүүлэхээр тохироод байна.

ЭС ЭНД ПИ АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ "В", ТӨЛӨВИЙГ "ТОГТВОРТОЙ" ХЭВЭЭР ҮЛДЭЭСНИЙГ БАТАЛГААЖУУЛЛАА

2022/07/22



Эс энд Пи агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В", төлөвийг "Тогтвортой" хэвээр үлдээснээ 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр зарлалаа. Тайланд 2022 онд Монгол Улсын эдийн засаг 2.5 хувиар өснө гэж таамаглажээ. Учир нь ирэх 2-3 жилийн эдийн засгийн өсөлтийн төлөв нь уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр эерэг үргэлжилж, 2025 он хүртэл ДНБ-ий бодит өсөлтийг жилд дунджаар 6.4% өсөх төлөвтэй. Мөн 2022 оноос хойш Монгол Улсын төсөв, өр, гадаад секторын нөхцөл байдал сайжирна. Монгол Улсын гадаад өр төлбөртэй холбоотой эрсдэлүүд нь олон улсын донор харилцагчдын зээлийн дэмжлэгээр буурч байна. Түүнчлэн Монголбанк 2020 оны 8 дугаар сард БНХАУ-ын Ардын банктай 15 тэрбум юанийн своп хэлцлээ 2023 оныг дуустал амжилттай сунгасан тул нийт гадаад өрийн тооцооллоос хасч авч үзсэн гэжээ.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА ГОАМЛ ПРОГРАМЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЛЭЭ

2022/07/26



Санхүүгийн мэдээллийн алба нь гоАМЛ программыг 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс үйл ажиллагаандаа нэвтрүүлээ. гоАМЛ программ нь НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас санхүүгийн мэдээллийн албанд зориулан боловсруулсан мэдээлэл боловсруулах, үйл ажиллагааг хялбаршуулсан, дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн цогц систем юм. Тус программыг нэвтрүүлснээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны мэдээлэл цуглуулах, солилцох болон тэмцэх үйл ажиллагаанд техник, технологийн дэвшилтэт орчныг ашиглан түргэн, шуурхай аюулгүй орчинд мэдээлэл солилцох, шаардлагатай арга хэмжээг хугацаа алдахгүй гаргах зорилготой юм.

МОНГОЛ УЛС ФАТФ-ЫН "ЗӨВЛӨМЖ 15"-ЫН ҮНЭЛГЭЭГ АХИУЛАВ

2022/08/01



Ази, Номхон Далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг /АНДМУТБ/-ийн 25 дахь жилийн ээлжит хуралд Монгол Улс оролцож, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг ФАТФ-ын Зөвлөмжид нийцүүлэн зохицуулсан талаарх ажлын тайлангаа амжилттай хамгааллаа. Ингэснээр Монгол Улсын ФАТФ-ын Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулж "дийлэнхийг хангасан" үнэлгээ авлаа. Монгол Улс ФАТФ-ын Техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн нийт 39 зөвлөмжид "хангалттай" болон "дийлэнхийг хангасан" гэх сайн үнэлгээтэй болж, энэхүү үзүүлэлтээрээ АНДМУТБ-ийн гишүүн улсуудаас хамгийн сайн үзүүлэлттэй 2 дахь улс болоод байна.

МОНГОЛБАНК БНСУ-ЫН “КАМСО” КОРПОРАЦТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ ҮЗЭГЛЭВ

2022/08/11



Монголбанк БНСУ-ын “Kamco” корпорацтай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулснаар хоёр байгууллага чанаргүй активыг үр ашигтайгаар бууруулах чиглэлээр мэдлэг, туршлага солилцох, хүний нөөцийг бэхжүүлэх, актив удирдлагын компанийн маркетинг, үйл ажиллагааны стратегийг хөгжүүлэх, актив удирдлагын компани байгуулахтай холбоотой эдийн засаг, хууль эрх зүйн мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх зэргээр өргөн хүрээнд хамтран ажиллах юм.

“Kamco” буюу Солонгосын хөрөнгийн удирдлагын корпорац нь тус улс дахь санхүүгийн байгууллагуудын чанаргүй зээлийг худалдан авах, шийдвэрлэх, бизнест бүтцийн өөрчлөлт хийх, зээлийн санхүүжилтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, хагас төрийн өмчийн байгууллага юм.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗААЛТЫН ТАЛААРХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2022/08/15



Төрөөс мөнгөний талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн заалтуудын хүрээнд “Уул уурхайн бус экспорт, аж үйлдвэржилтийг дэмжих дунд хугацааны бодлого”, “Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой ногоон санхүүжилт” сэдэвт танхим болон цахим хосолсон хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт төрийн яам агентлагууд болон олон улсын байгууллагууд оролцож, уул уурхайн бус салбарын экспорт, аж үйлдвэржилтийн хөгжил нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг дүгнэн, экспортын үйл ажиллагаа эрхлэгчдэд тулгарч буй хүндрэлүүд, хамтран нэгдэн ажиллах боломж болон бусад олон асуудлуудыг хөндөж хэлэлцэв.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН БНСУ-ЫН ТӨВ БАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ЧАНЁН РИТЭЙ УУЛЗЛАА

2022/08/18



Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн БНСУ-ын Төв банкны Ерөнхийлөгч Чанён Ритэй уулзаж, хоёр орны эдийн засаг, төв банк хоорондын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. БНСУ-ын Төв банк нь Азийн орнуудын төв банкууд, судалгааны байгууллагуудтай хамтран “Мэдлэгийн түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд Монголбанк тус хөтөлбөрт 2016 оноос хойш оролцож байна. Энэ хүрээнд төв банкууд хамтран Монгол Улсын валютын захын дэд бүтэц, санхүүгийн тогтвортой байдал болон макро зохистой бодлого зэрэг чиглэлээр сургалт семинар, судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэсэн юм.

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

2022/09/01




Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит бус хуралдаан 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр боллоо. Тус хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн даргалж, Сангийн сайд Б.Жавхлан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн болон бусад холбогдох албан тушаалтнууд оролцлоо. Хуралдаанаар банкуудын активын чанарын үнэлгээ үр дүн, эдийн засгийн төлөв байдал болон төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг хэлэлцлээ.

ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ЗЭЭЛД 2021 ОНД НИЙТ 1.0 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙГ 13.5 МЯНГАН ӨРХӨД ОЛГОВ


Цар тахлын тухай хууль, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах 2022 оны үндсэн чиглэл, “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”, Сангийн сайд Монгобанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу Монголбанкнаас ипотекийн

хөтөлбөрийг 2023 онд багтаан Засгийн газарт шат дараатай шилжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дээрх төлөвлөгөөний дагуу тус хугацаанд нийт 2.0 их наяд төгрөгийн хөтөлбөрийн зээл олгох төлөвлөгөөтэй байгаагаас одоогийн байдлаар 1.4 их наяд төгрөгийн хөтөлбөрийн зээлийг олгоод байна.

Дүрслэл 1. Ипотекийн хөтөлбөрийн зээл олголт (тэрбум ₮)



Дүрслэл 2. Ипотекийн төлбөр хойшлуулсан зээл (тэрбум ₮) болон зээлдэгчийн тоо



Харин энэ оны эхний 7 сард нийт 353.9 орчим тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийг 4.4 мянган өрхөд Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр олгоод байна. Мөн 2022 оны 8 дугаар сард 71.7 тэрбум төгрөг, 2022 оны 9 дүгээр сард 80 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээлийг олгохоор ажиллаж байна.

Цар тахлын хуулийн дагуу хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр 2020 оны 4 дүгээр сараас 2022 оныг дуустал 5 удаа хойшлуулсан (Дүрслэл 2). Сүүлийн буюу 5 дахь удаагийн төлбөр хойшлуулалтаар 3.4 их наяд гаруй төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 63,171

зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлууллаа. Дээрх зээлдэгчид 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оныг дуустал нийт 195.12 тэрбум төгрөг (77.9 тэрбум үндсэн төлбөр, 117.3 тэрбум төгрөгийн хүүний төлбөр)-ийн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй зээлд тавигдах шаардлага, шалгуур өөрчлөлт ороогүй буюу “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам” болон “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу хэвийн хэрэгжиж байна.

ИНФЛЯЦЫГ ДУНД ХУГАЦААНД 6+/-2 ХУВИЙН ЗОРИЛТЫН ОРЧИМД ТОГТВОРЖУУЛАХ МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛНЭ



Эдийн засагт гадаад хүчин зүйлс илүүтэй давамгайлсан өнөөгийн нөхцөл байдлыг эрсдэлгүй даван туулахад төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваатай ярилцлаа.

- **Төв банкнаас өндөр инфляцын эсрэг хэрэгжүүлж байгаа 3 улирал дамнасан мөнгөний бодлогын үр нөлөө өнөөгийн байдлаар эдийн засагт зорилгоо хэрхэн хангаж байна вэ?**

Төв банкнаас инфляцын эсрэг шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, оны эхэн үетэй харьцуулахад бодлогын хүүг 2 дахин нэмэгдүүлж 12 хувьд хүргээд байна. Дан ганц бодлогын хүү бус инфляцыг өдөөж байсан зарим гадаад хүчин зүйлс, тээвэр логиستيкийн нөхцөл байдал харьцангуй сайжирч байгаа нь инфляц буурахад

нөлөөлж байна. Шатахуун, мах, хүнсний ногоо гэх мэт дотоод хүнсний барааны үнэ бас инфляц буурахад нөлөөлж байна. Засгийн газраас анхаарал хандуулж, авч хэрэгжүүлж буй зохион байгуулалт бодлого зохицуулалт ч үр дүнгээ өгч байх шиг байна. Сүүлийн саруудад инфляц буурах хандлагатай болж байгааг энд онцлох нь зүйтэй. Тухайлбал, инфляц энэ оны 8-р сард улсын хэмжээнд 14.4 хувьд хүрсэн нь 6-р сарын оргил үеэс даруй 2.5 нэгж хувиар буурсан хэмжээ юм. Цаашид инфляц үргэлжлэн буурч дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжих хүлээлт хэвээр байгаа хэдий ч гадаад орчны

тааварлашгүй нөхцөл байдал гол эрсдэл болсоор байна.

- **Гадаад орчноос үүдэлтэй геополитикийн тодорхой бус байдлаас манай эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг бууруулахын тулд бодлогын арга хэрэгслүүдээ нэмэгдүүлэх шаардлагатай юу?**

Үнийн өсөлт дэлхийн нийтийг хамарч, олон оронд сүүлийн хэдэн 10 жилд ажиглагдаагүй өндөр инфляц бий болж байна. Үүнд глобал эдийн засаг цар тахлын хүнд үеэс бүрэн сэргээгүй байхад геополитикийн хямрал нүүрлэсэн нь гол нөлөөтэй. Иймээс бодлогын оновчтой

хариу арга хэмжээг авахын тулд макро эдийн засагт үзүүлж буй гадаад орчны нөлөөг зөв таних нь нэн чухал юм. Учир нь үүсээд буй өрнөл нь бодлогын арга хэрэгслээр зохицуулагдах эсэх нь бий болсон өөрчлөлтийн шалтгаан ямар байхаас ихээхэн хамаарна. Хэдийгээр глобал эдийн засагт үүссэн өөрчлөлтийг хүлээж авахаас өөр аргагүй боловч эрсдэлээ бууруулах, санхүүгийн нөөцөө хамгаалах, төрийн байгууллагууд бодлогын орон зайгаа гамнах нь юу ч болж магадгүй ийм тодорхой бус орчинд маш чухал болж байна.

- **АНУ-ын Холбооны нөөцийн сангийн тэргүүн бодлогын хүүгээ эрчимтэй өсгөнө гэдгээ мэдэгдсэн нь Монголбанкнаас хэрэгжүүлэх мөнгөний бодлогын төсөөлөлд хэрхэн нөлөөлөх бол?**

АНУ-д инфляцын түвшин зорилтоос нь 4 дахин давчаад байна. Үүний дээр сүүлийн сард тус улсын инфляц хүлээлтээс өндөр гарсан учраас Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ цаашид үргэлжлүүлэн эрчимтэй нэмэгдүүлэх хандлагатай болсон. Гэхдээ нэг удаагийн шийдвэрээр ихдээ 0.75 нэгж хувиар хүүгээ нэмэгдүүлж, ирэх онд 4-5 хувьд хүргэхээр байгаа нь Монгол төдийгүй дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээл, хөгжиж буй орнуудын эдийн засагт маш том сорилт болж байна. Гадаад хүүний энэхүү өсөлт нь манай улсын хувьд гадаад

зээл, дахин санхүүжилтийн хүүг өсгөх, валютын ханшинд тохируулга хийх, гадаад, дотоод хүүний тэнцвэрийг хангах зэрэг сорилтуудыг бий болгож байна. Мэдээж хэрэг хүү, ханшийн тохиргоо нь инфляц, эдийн засаг, зээлийн нийлүүлэлт, хадгаламж, зээлийн хүү зэрэгт нөлөөлнө.

- **Жил дуусахад 1 улирал үлджээ. Энэ оны мөнгөний бодлого эдийн засгийг сэргээхэд зорьсон. Үр дүнг хэрхэн дүгнэх вэ?**

КОВИД-ын эхнээс сүүлийн 2 жил гаруйн хугацаанд улсын санхүүгийн хуримтлуулсан нөөц, гадаад санхүүгийн дэмжлэгт тулгуурлан хэрэгжүүлсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлого үр дүнгээ өгч, хөл хорионы дэглэм суларснаар эдийн засаг энэ оны эхний хагас жилд 1.9 хувиар өссөн үр дүнд хүрлээ. Шууд болон шууд бус санхүүжилт, бага бодлогын хүү, зээлдэгчийн төлбөрийн хойшлуулалт, банк, санхүүгийн байгууллагуудад хэрэгжүүлсэн зохицуулалт хөнгөлөлт зэрэг санхүүгийн механизм нь зээлийн тасалдлыг арилгаж, зээлийг сэргээж улмаар эдийн засгийн өсөлт, ялангуяа уул уурхайн бус салбарын сэргэлтэд нөлөөллөө. Мөн тээвэр, уул уурхай, барилгын салбараас бусад бүх салбар өсөж уул уурхайн бус салбар нийт дүнгээр 2019 оны мөн үеэс 5.2 хувиар өндөр байгаа нь дотоод эдийн засаг цар тахлын өмнөх үеийг давсныг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, бодит эдийн засгийн

идэвхжил бидний хүлээлтэд хүрч сэргэсэн гэж хэлж болно. Нэгэнт уул уурхайгаас бусад салбар хямралын өмнөх буюу 2019 оны мөн үеийн түвшинг давсан тул цаашид бодлогыг дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглүүлж, тодорхой тохиргоог хийж байна. Цаашид экспортын салбар сэргэх нь маш чухал ач холбогдолтой.

- **Ирэх онд төрөөс баримтлах мөнгөний бодлогын гол зорилтод инфляцын зорилтыг хэдээр тогтоож байгаа вэ? Зорилтыг өөрчилж байгаа юу?**

Инфляцын зорилт ба төсөөлөл нь ялгаатай агуулгатай. Зорилт бол жил болгон өөрчлөгдөх ёсгүй бөгөөд дунд хугацаанд инфляцыг тогтворжуулах хэмжээ юм. Харин инфляцын төсөөлөл, таамаглал бол хүлээгдэж буй түвшин юм. Төсөөлөл болон бодит гүйцэтгэл зорилтоос зөрүүтэй үед түүнийг ирээдүйд зорилтот түвшин рүү тогтворжуулахад мөнгөний бодлого чиглэдэг. Хэдийгээр гадаад инфляц, инфляцад нөлөөлөх хүчин зүйлс маш тодорхойгүй байгаа боловч суурь төсөөллөөр ирэх жилийн эхний 3 улирлын турш инфляц 8%-иас дээш байхаар байгаа бол зорилт $6(+/-2)$ хэвээр байна. Өөрөөр хэлбэл, инфляцыг ирэх жилийн эцэс, 2024 оны эхэн гэхэд $6(+/-2)$ хувийн зорилтын орчимд тогтворжуулах мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

- **Үүнээс гадна макро зохистой бодлогын хүрээнд санхүүжилтийг дэмжихэд чиглэсэн ямар бодлого хэрэгжих вэ?**

Монголбанкны хувьд санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийн шинжилгээ, мониторингийг хийж, эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Монголбанкнаас 2018 оны Төв банкны хуулийн нэмэлт өөрчлөлтөөс хойш зээлийн хэт өсөлт, зээлийн тасалдлын эрсдэлийг оновчтой удирдаж

бууруулахад чиглэсэн олон улсад өргөн хэрэглэгддэг макро зохистой бодлогын хэрэгслүүдийг ашиглан ажиллаж байна. Санхүүгийн сектор тогтвортой байх нь санхүүжилтийг дэмжих чухал хүчин зүйл учраас макро зохистой бодлого үүнд төвлөрч ажиллана. Мөнгөний бодлогын төлөв мэдэгдэхүйц хатуурсан тул инфляцыг тогтворжуулах хүртэл санхүүгийн нөхцөл хатуурах нь ойлгомжтой. Энэ нь зээлийн хүүний өсөлт, шинэ зээл олголтын шалгуур чангарах гэх зэргээр илэрнэ. Харин инфляц, ханш тогтворжих нь мөнгө, төсвийн бодлогоос гадна


экспортын гүйцэтгэл, түүний бодит орлого, тээвэр-логистик гэх мэт бусад салбаруудын үйл ажиллагааны тасралтгүй байдлаас шууд хамаарч байна. Энэ үйл ажиллагаанууд тасралтгүй тогтвортой хэрэгжсэнээр зээлийн, санхүүгийн нөхцөл эргэж зөөлрөх хугацаа наашилна.

Ярилцсанд баярлалаа


МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХҮҮНИЙ ТОЙМ

2022

Инфляц



Бодлогын хүү



Монголбанк 2022 оны 1-р сараас эхлэн бодлогын хүүг шат дараатайгаар нэмэгдүүлснээр

Одоогийн өндөр инфляцад шууд нөлөөлж чадахгүй ч үүнээс үүсэх хоёр дох үеийн нөлөөг бууруулах;

Ирээдүйн инфляцын хүлээлтийг тогтворжуулах;

Гадаад суурь хүү хурдтай нэмэгдсэн энэ үед гадаад-дотоод хүүний тэнцвэрийг хадгалах үр нөлөөтэй.



Нийт инфляцын талаас илүү хувийг хэрэглээний сагсны 40 хувийг бүрдүүлдэг импортын бараа бүтээгдэхүүний шууд нөлөө тайлбарлаж байна. Үүний дээр импортын орц болон шатахууны үнийн өсөлтөөр дамжин дотоодын бараа, үйлчилгээний үйлдвэр, тээврийн зардлыг нэмэгдүүлэх шууд бус нөлөөг үзүүлж байна.



Дээрх хүчин зүйлсийн нөлөө ирэх улирлуудад үргэлжлэх хандлагатай бөгөөд өрхийн хэрэглээ сэргэж, уул уурхайн бус салбаруудын үйл ажиллагаа тогтворжиж эхэлсэнтэй уялдан эрэлтийн шалтгаантай инфляц харьцангуй алгуур нэмэгдэх төлөвтэй байна.



БНХАУ-ын ковидын эсрэг бодлоготой холбоотойгоор үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт хязгаарлагдаж байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөг 2022 онд үзүүлэхээр байна.



2022/06/22

Гадаад инфляц, ханшийн нөлөөгөөр импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн нь бусад дотоодын бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөж байна.

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өссөнөөс дотоодын шатахууны үнэ нэмэгдсэн бол тээвэр, логистикийн саатал, нийлүүлэлтийн доголдол үргэлжилж, үйлдвэрлэлийн орц болон тээврийн зардал нэмэгдсэн нь хүнсний үнэ сүүлийн 2 сард хурдтай өсөхөд нөлөөллөө.



2022 оны 1 дүгээр улиралд сүүлийн 5 улирал дараалан агшаад байсан өрхийн хэрэглээ сэргэж, дотоод эрэлт нэмэгдэв.



Мөнгөний бодлогын хороо инфляцын хүлээлтийг дунд хугацаанд тогтворжуулах, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг зохистой түвшинд хангах, гадаад суурь хүү өсөж буй орчинд төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор бодлогын хүүг өсгөх шийдвэрийг гаргав.



Гадаад эрэлтийн төлөв, хилийн хязгаарлалтын асуудлаас шалтгаалан уул уурхайн салбарын өсөлт энэ онд удаашрахаар байгаа бол цар тахлын хязгаарлалтууд суларч, дотоод эрэлт сайжирснаар уул уурхайн бус салбарын сэргэлт үргэлжлэхээр байна.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗААЛТЫН ТАЛААР ОРОЛЦОГЧ ТАЛЦУД ЮУ ХЭЛЭВ?



Төрөөс мөнгөний талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн заалтуудын хүрээнд “Уул уурхайн бус экспорт, аж үйлдвэржилтийг дэмжих дунд хугацааны бодлого”, “Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой ногоон санхүүжилт” сэдвийн дор судлаачдын дэвшүүлсэн байр суурийг толилуулж байна.



О.ТҮМЭН-АМАР
(МҮХАҮТ-ын Судалгааны
институтын дарга)

Эдийн засаг, гадаад худалдаа, олон улсын харилцааны тодорхойгүй, тааламжгүй орчин бий болж, цар тахлын нөхцөл байдалтай дасан зохицож бизнес, эдийн засгаа сэргээх амаргүй цаг үед бизнес эрхлэгчдийн бизнесийн орчиндоо итгэх итгэл -0.05 болж, 2020 оноос сэргэсэн дүнтэй байна. Гэсэн хэдий ч бизнес итгэлийн индекс хасах утгатай байгаа нь манай улсын бизнесийн орчинд сайжруулах, анхаарах асуудлууд олон байгааг илтгэж байна. Эдийн засгийн гол салбаруудаас барилга, үйлчилгээний салбарын бизнесүүдийн итгэл хамгийн бага байна. Бизнес эрхлэгчид 2022 онд бизнесийн ерөнхий орчин өмнөх онтой ойролцоо жил болно. Харин хөрөнгө оруулалт илүү сайжирна гэсэн хүлээлттэй байна. Бизнесийн үйл ажиллагаа идэвхжин, бизнесийн орчин бага зэрэг сайжирсан үзүүлэлтүүд ажиглагдаж байгаа хэдий ч бизнес эрхлэгчид цар тахлын өмнөх үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний хүнд суртал ихэссэн гэж дүгнэж байна. МҮХАҮТ-ын “Хүнд суртлын индекс” судалгааны дүнгээр бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ авахдаа дунджаар 6 баримт бичиг бүрдүүлж, 3 төрийн албан хаагчтай харьцаж, 13 хоног зарцуулж, 360 мянган төгрөгийн албан зардал гаргадаг. Түүнчлэн бизнес эрхлэгчдийн 45 хувь нь төрийн үйлчилгээг авахдаа дунджаар 219 мянган төгрөгийн албан бус зардал гаргасан байна.

Бизнесийн орчныг сайжруулахад төрийн зүгээс татвар, зээлийн оновчтой бодитой дэмжлэг үзүүлэн, төрийн үйлчилгээний цахим шилжилтийг хурдасгах замаар хүнд суртлыг бууруулж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, бодлогын тогтвортой байдалд анхаарч ажиллах шаардлагатай байна.



Ц.ЦЭРЭНДАВАА
(Монголбанкны Судалгаа
Статистикийн газрын
эдийн засагч)

Уул уурхайн бус экспортлогч 157 аж ахуйн нэгжүүдээс экспортлогчдын бизнесийн орчны нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодруулахаар түүвэр судалгаа авч, үр дүнг нэгтгэлээ. Судалгааны үр дүнгээс харахад бараа нийлүүлэх хугацаа Ковид-19 цар тахал эхлэхээс өмнө буюу 2020 оноос өмнө дунджаар 26 хоног байсан бол эхэлснээс хойш 59 хоног болж, гадаад гүйлгээний хугацаа 6-аас 10 хоног болж тус тус нэмэгдсэн байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардлын 59%-ийг түүхий эд бүрдүүлж байгаа бөгөөд уг түүхий эдийн 22%-ийг импортоор авч байна. Импортоор авч буй түүхий эдийг дотооддоо хангах боломжтой эсэхийг тодруулахад 49% нь боломжтой гэж хариулсан ч импортын түүхий эд стандартын шаардлагад илүү нийцдэг тул авах шаардлагатай байдаг байна. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 80% нь 3 хүртэл жилийн хугацаатай зээлийн санхүүжилт авсан байгаагаас банкнаас авсан төгрөгийн зээл дийлэнх хувийг бүрдүүлж байна. Уул уурхайн бус экспортлогчдын хувьд экспортын гарцыг нэмэгдүүлэхэд саад болж буй гол хүндрэл санхүүжилтийн асуудал байна гэж үзэж байгаа хэдий ч төр засгийн зүгээс

- Хилийн тээврийн зохицуулалтыг сайжруулах,
- Экспортын зах зээлийг тэлэх буюу сурталчлан таниулах,
- Чөлөөт худалдааны хэлэлцээрийг хийх,

Хөнгөлөлттэй санхүүжилтийн дэмжлэгийн арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзсэн.



Э.НАНДИН-ЭРДЭНЭ
(Монголын тогтвортой
санхүүгийн (ТоС)
холбооны Бодлого,
хамтын ажиллагаа
хариуцсан Ахлах
менежер)

Тогтвортой, ногоон санхүүжилтийн бодлогын зорилт нь 2019 оноос эхлэн Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгагдаж ирсэн нь уг бодлогын хэрэгсэл нь тогтвортой санхүүжилтийг Монгол Улсад хөгжүүлэх гол хөшүүрэг болсоор байна. Санхүүгийн салбар нь Олон улсын өмнө Монгол Улсаас хүлээсэн тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үүрэг амлалтуудыг биелүүлэх гол хурдасгуур салбар юм. ОУСК, Тогтвортой банк санхүүгийн холбооноос 2021 онд Монгол Улсыг тогтвортой санхүүжилтийг “ахисан түвшинд” хэрэгжүүлж буй орнуудын нэгээр тодруулсан.

Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын зорилтуудыг биелүүлэхэд 2030 он хүртэл санхүүгийн салбараас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг” баримт бичгийг 2022 оны 3 дугаар сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр баталсан. Энэхүү баримт бичиг нь тогтвортой санхүүг хөгжүүлэх суурь нөхцөл, бодлогын орчныг бүрдүүлэх, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой хөгжилд чиглүүлэх, ногоон, тогтвортой, уур амьсгалын санхүүжилтийн урсгалыг нэмэгдүүлэх, үндэсний ногоон санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх, байгаль орчин, нийгэм, засаглал ба уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй тайлагналыг дэмжих гэсэн 6 тулгуураас бүрдсэн юм.

Эдгээр багц арга хэмжээний төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээнүүдийг Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлд оруулахаар санал хүргүүлээ. Үүнд: Монгол Улсын дунд ба урт хугацааны хөгжлийн

бодлого, төлөвлөлтөд тусгагдсан зорилтуудтай уялдсан Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн таксономыг банкны салбарт нэвтрүүлж, тогтвортой санхүүжилтийн үр дүн, нөлөөллийг хэмжих, тайлагнах аргачлал боловсруулна.

- Ногоон зээлийн багцыг банкны салбарт 10 хувьд, банкны бус салбарт 5 хувьд хүргэх зорилтын дагуу ногоон зээл олголтыг дэмжих бодлогын урамшуулал, хөшүүргүүдийг судалж, хамгийн оновчтой, үр дүнтэй шийдлийг нэвтрүүлэх. Ногоон цахим бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломжийг судалж, тодорхойлно.
- Санхүүгийн салбарт жендерийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлж, хүйсээр ангилсан статистикийг цуглуулж, чадавх бэхжүүлэх ажлыг цуврал байдлаар зохион байгуулна.
- Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах ба дасан зохицох чиглэлд санхүүгийн салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх хүрээнд эрсдэлийн шинжилгээ, тооцоо судалгаа хийж, түүнд шаардлагатай бодлогын хөшүүргийн арга хэмжээнүүд нэвтрүүлнэ. Санхүүгийн салбарт зориулсан Тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн тайлагналын аргачлал боловсруулж, нэвтрүүлнэ ээрэг бодлогын шийдвэрүүдийг тусгахаар зорьж байна.



А.НАРАНГАРВУУ
(БОАЖА-ны Уур
амьсгалын өөрчлөлтийн
газрын мэргэжилтэн)

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхий нийтээр хариу арга хэмжээ төлөвлөж буй өнөөгийн нөхцөлд төсвийн тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүнд нийцсэн төсвийн төлөвлөлтийг хийх шаардлагатай байна. Хэрэв уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй тохиолдолд Ази, Номхон далайн бүс нутгийн ДНБ 2050 он гэхэд 3.3%-иар, 2100 он гэхэд 10.0%-иар буурна гэсэн тооцоо бий.

Одоо хэрэгжиж байгаа Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилтын хугацаанд Монгол Улсад ихээхэн хэмжээний хөрөнгө, санхүүжилт хуваарилах боломжтой шинэ хандивлагч гарч ирэх магадлал бага байна. Тиймээс засгийн газар одоо байгаа хандивлагч байгууллагуудтай ойр ажиллаж уур амьсгалын санхүүжилтийг ҮТХН-ийн зорилтын тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад чиглүүлэхийн зэрэгцээ 2025 оноос хойш хийгдэх хөрөнгө оруулалттай холбоотойгоор хандивлагч байгууллагын тоог нэмэгдүүлэх, мөн Монгол Улсын хөгжлийг тууштай дэмждэг уламжлалт хандивлагчдын санхүүжилтийг шингээх чадавхыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь чухал юм. Монгол Улс цаашид санхүүжилтийн холимог арга ашиглах зайлшгүй шаардлагатай бөгөөд үүний тулд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын урсгал, оролцоог нэмэгдүүлэх, түүнд чиглэсэн тусгайлсан дэмжлэг, засгийн газрын арга хэмжээг дорвитой төлөвлөхгүйгээр хэрэгжилтийг хангах боломжгүй. Уур амьсгалын санхүүжилтийн урсгалыг олон улс, төр, хувийн хэвшлийн зүгээс нэмэгдүүлэхэд:

Уур амьсгалын санхүүжилтийн хяналт, тайлагналт, баталгаажуулалтын тогтолцоо (MRV)-г байгуулах замаар төсвийн тогтолцоонд ногоон ангилалзүй, хяналтын системийг бэхжүүлэн нэвтрүүлэх, ингэснээр дотоодын болон Олон улсын санхүүжилтийн урсгалыг ил тод тайлагнах, угсалыг нэмэгдүүлэн татах үндсэн хөшүүрэг бий болох юм.

“Тогтвортой санхүүжилтийн замын зураг”-ийн дагуу ногоон санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн бодлого төлөвлөлт, санхүүжилтийг хариуцаж буй байгууллагуудыг шаардлагатай техникийн заавар, мэдээллээр хангах замаар чадавхжуулах.

МНСК-ийн үйл ажиллагааны цар хүрээг тэлэх, төсөл хөгжүүлэлт, хэрэгжүүлэлтийн оролцогчдын тоог нэмэгдүүлэх чиглэлээр Олон улсны санхүүгийн байгууллагуудаас дэмжлэг авах (ЖДҮ болон өрхүүдэд зээл олгох).

Урт хугацаат бондын эх үүсвэр, дахин санхүүжилтийн механизмыг ашиглан Монголын хөрөнгийн зах зээл болон ногоон санхүүжилтийг дэмжих.

Сэргээгдэх эрчим хүч болон тээврийн салбарын бүтээн байгуулалтын томоохон төслүүдэд анхаарч ногоон төслийн хөгжүүлэлтэд ОУСБ, хөгжлийн банкуудаас дэмжлэг хүсэх, цаашлаад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ногоон төсөл боловсруулалтын чадавхыг сайжруулах шаардлагатай байна.



Т.ДЭЛГЭРНАРАН
(НҮБ-ын Хөгжлийн
хөтөлбөр, Төслийн
үндэсний зохицуулагч)

Монгол Улс “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд “нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, болон иргэдийн амьдралын чанар”-аар Азид тэргүүлэгч орнуудын нэг болохын зэрэгцээ ногоон хөгжлийг дэмжих, экосистемийн тэнцвэрт байдал, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, одоо болон ирээдүйн хойч үедээ үр шимийг нь хүртээх нөхцөлийг бүрдүүлж, дундаж давхарга давамгайлсан нийгмийг бий болгох зорилго дэвшүүлээд байна.

Энэхүү зорилтуудыг Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-уудтай нийцүүлэн 2030 он хүртэл хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний санхүүжилт шаардлагатай байгаа юм. Тухайлбал, ТХЗ-даа хүрэхэд жил бүр ДНБ-ий 18 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт санхүүжилт шаардлагатай болох урьдчилсан тооцоо гараад байна. Энэхүү нэмэлт санхүүжилтийн хэрэгцээг хангахад дан ганц улсын төсвийн эх үүсвэр хангалтгүй юм. Иймд санхүүгийн нэмэлт олон эх үүсвэрүүдийг ялангуяа, хувийн хэвшлийн хөрөнгийг үндэсний ТХЗ-д чиглүүлэх, нэмэгдүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

ТХЗ-д хөрөнгө оруулах нь нийгэм, байгаль орчны үр ашиг өндөртэй боловч, санхүүгийн ашиг багатай байдаг, эдийн засгийн ойлголтоор авч үзвэл нийтийн барааны шинж чанартай тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад нэгдсэн бодлого, санхүүгийн оновчтой хөшүүргүүд шаардлагатай. Нөгөө талаар, хязгаарлагдмал санхүүгийн нөөц, эх үүсвэрүүдийг харилцан уялдуулж, үндэсний тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд чиглүүлж улмаар, зарцуулсан хөрөнгө бүрийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд харилцан уялдаатай бодлогууд, механизмууд зайлшгүй шаардлагатай болохыг Олон улсын байгууллагууд зөвлөж байгаа. Үүний нэг жишээ нь 2015 онд хуралдсан НҮБ-ын Хөгжлийн санхүүжилтийн олон улсын 3 дугаар чуулганаар Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэхийг зөвлөсөн юм. Энэ дагуу Сангийн яам бусад салбарын яамд, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Олон улсын байгууллагууд, салбарын мэргэжлийн холбоодтой хамтран, Тогтвортой хөгжлийн санхүүгийн нэгдсэн стратегийн төслийг боловсруулж, Тогтвортой хөгжлийн үндэсний хороо хэлэлцэж, дэмжсэн нь Монгол Улсын хувьд тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд маш чухал алхам болсон гэж үзэж байна.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

БИСМАН ТЭНГЭР VIASRAVANA

Санскрит: Виасравана

Түвэд: Намсрай, Намтойсрай

XIX - XX зуун

Жин: 5291.1 гр

Өндөр: 25 см, **суурь:** 19.6 x 11.2 см

Алт шармал зэс, хөөмөл

Торгон буюу зээгт наамлын урлаг нь Төв Азийн Хүннү нарын үеэс улбаатай бөгөөд бурханы шашин дэлгэрэхэд тусгай нэгэн төрөл урлал болон хөгжсөөр XIX зуунд оргил үедээ хүрсэн юм.

Зээгт наамлын онцлог нь эхлээд торгон дээр бурхан дүрслэлийн тиг, баримтлалын дагуу хар зургаа гаргасны хойно торгыг өнгө хоршуулан нааж, алт мөнгөн саа, туушингаар зээглэж, шүр, сувд, оюу зэрэг эрдэнэсийн чулуу шигтгэдэг нарийн ажиллагаатай урлал билээ. Мөн өнгө зохицол хийгээд зохиомж дүрслэл нь уран зурагтай эн тэнцэх тул торгон зураг хэмээн нэрлэгдэж байжээ.

Монголчууд торгон зургийн урлалаар Дорно дахины урлагт тэргүүлэх байр суурь эзлэх бөгөөд олон арван хосгүй

бүтээлүүдийг урласан түүхтэй. Тухайлбал зураач, уран наамалч Т.Цэнд 1898 онд жил бүрийн зуны адаг сард болдог Хүрээ цамд зориулан 13.9 x 10.45 метрийн хэмжээтэй

Очирваань бурханыг урласан нь Монгол болон торгон зургийн хосгүй нэгэн урлалд зүй ёсоор тооцогддог.





МОНГОЛБАНКНЫ УДИРДЛАГУУДЫН СЭТГҮҮЛЧДЭД ӨГСӨН МЭДЭЭЛЛЭЭС

Монголбанк эдийн засгийн нөхцөл байдалд бодлогын ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж буй талаар сэтгүүлчдэд танилцуулсан юм. Энэ үеэр өрнөсөн асуулт хариултыг дэлгэрэнгүй байдлаар танилцуулж байна.

Эдийн засгийн хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар мэдээлэл хийхдээ төлбөрийн тэнцлийн алдагдал их байгаа учраас мөнгөний бодлогыг хатууруулах замаар бодлогын хариу арга хэмжээ авна гэж мэдэгдсэн. Энэ нь зах зээл дээр ихээхэн хүлээлтийг үүсгэлээ. Үүний сөрөг нөлөөллийг хэрхэн харж байна вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.ЛХАГВАСҮРЭН:

Бид өнгөрсөн намраас эхлэн мөнгөний бодлогоо аажмаар чангаруулж ирсэн. Энэ шийдвэрүүдээ зөв байлаа гэж дүгнэмээр байна. Манай улсын эдийн засгийн өсөлт (ЭЗӨ) энэ оны хагас жилийн байдлаар 1.9 хувийн өсөлттэй гарсан. ЭЗӨ нэгдүгээр улиралд -3.8 хувь байсан. Энэ хоёрын нийлбэрээр 1.9 хувьтай гарна гэдэг нь хоёрдугаар улиралд Монгол Улсын эдийн засаг бараг 5.6 орчим хувиар өсчихсөн байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, өсөлт нь өмнөх улирлын хасахаа хааснаар нэмэх үзүүлэлттэй гарчихсан байгаа юм. Энэ эрчээрээ он дуустал явна. Тиймээс ЭЗӨ бидний төсөөллийн орчимд буюу 2.6 орчим хувь дээр очих боломжтой байна. Бидний хувьд бодлогын хүүн дээр зөөлөн арга хэмжээ авсан учраас эдийн засаг тодорхой хэмжээгээр тэтгэгдээд байна. Хэдийгээр мөнгөний нийлүүлэлт м2 өсөөгүй ч гэсэн, зээл 20 хувийн өсөлттэй байна. Энэ нь бодит эдийн засагт санхүүжилт хийгдэж байгааг илтгэх тоо. Тэгэхээр манай эдийн засаг бидний төсөөлж байсны дагуу явж байгаа учраас хэрэгжүүлж буй бодлого зөв байжээ гэж хэлэх байна. Хоёрдугаарт, эдийн засгийн өсөлтийг харвал уул уурхайн бус салбар

буюу хөдөө аж ахуй, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрийн салбар өссөн байна. Хамгийн их хүмүүс ажилладаг, хүмүүсийн цалин орлоготой хамгийн их холбоотой салбар нь өсчихсөн байгаа учраас бидний хувьд үүнийг зөв өсөлт гэж үзээд, дэмжмээр байгаа юм. Хэрвээ мөнгөний бодлогыг хатууруулбал, тэр өсөлтүүд байхгүй болчих гээд байна. Нөгөө талаас уул уурхайн салбар 2019 оны эхний хагас жилтэй харьцуулахад 39 хувийн уналттай хэвээрээ л байна. Уул уурхайгаа дагаад тээврийн салбар 40 хувийн уналтыг үзүүлсэн. Нүүрсээ зөөж чадахгүй л байна гэсэн үг. Түүнчлэн барилгын салбарын уналт 40 хувьтай байна. Тэгэхээр энэ гурван салбар уналттай байна. Бусад салбаруудад сэргэлт бий болчихсон. Тэр бүү хэл, хөдөө аж ахуйн салбар 2019 оны эхний хагас жилтэй харьцуулахад бүр 19 хувиар өсчихсөн байгаа. Ямар ч байсан Монгол Улсын зарим нэг салбарууд Ковидын хүндрэлийг даваад, 2019 оны эхний хагасаасаа илүү гарчихсан байна. Бидний хувьд инфляцаа бодохоор мэдээж бодлогын хүүг өсгөмөөр байна. Гэхдээ эдийн засгийн өсөлтөө бодох хэрэгтэй тул маш болгоомжтой л хандах ёстой зүйл юм.

Эдийн засагчдын хувьд Монголбанкны мөнгөний бодлогын арга хэмжээ хэтэрхий оройтсон гэдэг шүүмжлэлийг хэлж байгаа. Эртнээс бага, багаар арга хэмжээ авах боломжтой байхад яг хаврын бизнесийн идэвхжлийн үед буюу 3 дугаар сард бодлогын хүүг өсгөсөн нь бизнесийнхэнд ихээхэн дарамт болсон гэж

байгаа. Энэ талаар?**Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:**

Бүх эдийн засагчид ийм байр суурь илэрхийлэхгүй байгаа гэж бодож байна. Тэр битгий хэл мөнгөний бодлогын хүүгээ өсгөж болохгүй, бууруулах шаардлагатай гэж үздэг эдийн засагчид ч байгаа. Нөгөө талдаа 10 хувь хүртэл өсгөхөөр харин ч их удаан өсгөлөө гэж шүүмжилдэг тал ч бий. Эдийн засагчдын хувьд хоёр хуваагдчихсан байдаг. Хоцорсон гэх шүүмжлэл ямар өнцгөөс харж байна вэ гэдгээс л болно. Гэхдээ миний түрүүн хэлсэнчлэн манай бодлогын хүү харин ч хавьгүй эрт буюу өнгөрсөн намраас өсөж эхэлсэн. Гэхдээ энэ бол зөвхөн бодлогын хүү шүү дээ. Тодруулбал, бодлогын хүү гэдэг бол ердөө нэг л хэрэгсэл. Гэтэл бид мөнгөний бодлогын бусад олон арга хэрэгслээр бодлогоо чангаруулсан. Заавал байлгах нөөц, хүүгийн коридор гэх мэтчилэн. Тэгэхээр мөнгөний бодлогыг хатууруулж байгаа арга хэмжээ нь зөөлдөөгүй л гэж хэлнэ.

Активын чанарын үнэлгээг зөвхөн IPO гаргахад зориулж дахиж хийж байгаа юу, эсвэл өөр тодорхой шалтгаан бас байгаа юу, үр дүнгийн хувьд ямар байна вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

Активын чанарын үнэлгээ хийгдээд дууссан. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр танилцуулсан. Ковидын үеэр нэлээд олон хөнгөлөлт, чөлөөлөлт өгөөд, зээлүүдэд бүтцийн өөрчлөлт хийгдсэн. Тэр утгаараа олон улсын байгууллагын зүгээс ковидын үед банкны секторт юу болсныг та нар яг сайн мэдэж байгаа юу, нэг шалгаж үзсэн нь дээр байх аа гэсэн байгаа. Энэ утгаараа Активын чанарын үнэлгээг хийгээч гэдэг зөвлөмжийг өгсөн. Тэрнийх нь дагуу бид хэд сая хийчихлээ. 2017 оны шалгалт банкуудад маш их цочроо өгсөн. Тэрнээс хойш банкууд нэлээд сайн ажиллалаа. Хоёрдугаарт, ковидын хоёр жилд банкууд маш болгоомжтой ажиллаж, зээл маш бага гаргасан. Өнгөрсөн онд гаргасан зээлүүд ихэнх нь Засгийн газрын хөтөлбөрийн, татаастай зээл байсан. Арилжааны зээл дээрээ маш болгоомжтой хандсан учраас саяын

шалгалтаар үр дүн маш боломжийн гарсан. Өөрийн хөрөнгө бараг дутагдаагүй.

Ипотекийн зээл яагаад гарахгүй байна вэ гэдэг маш их хүлээлт үүсчихлээ. Хугацааг хойшлуулсантай холбоотой юу, эсвэл өөр шалтгаан байна уу?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

Ипотекийн зээл хэвийн олгогдож байгаа. Учир нь төв банкнаас хийж байгаа санхүүжилт зогсоогүй үргэлжилсэн хэвээр байгааг хэлэх нь зүйтэй. Харин санхүүжилтийн хэмжээг өнгөрсөн жилийнхтэй харьцуулбал, мэдээж буурсан. Энэ нь ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсантай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, зээлдэгчийн эргэн төлөлтөөр эх үүсвэр бүрддэг тул багассан. Банкныхан ч багассан, манай мөнгө ч багасаж байна. Гэхдээ бид аль болох огцом бууруулахгүйгээр, хэвийн хангаж байна. Хамгийн сүүлд долоодугаар сард 75.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсон.

Нөөцийн удирдлага зах зээлийн газар (УСЗЗГ)-ын захирал А.Энхжин:

Тодруулж хэлэхэд, он гарснаас хойш 4577 иргэнд ипотекийн зээл олгосон. Нийтдээ 410 орчим тэрбум төгрөгийн зээл гэсэн үг. Үүний 224 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээр, 184.6 тэрбум төгрөг нь банкны эх үүсвэр. Нийт гарч байгаа зээлийн санхүүжилтийн 60 хувь нь Монголбанкны эх үүсвэрээр, 40 хувь нь банкны эх үүсвэрээр олгогдож байна. Гарсан зээлийн тоогоор авч үзвэл 49 орчим хувиар, санхүүжилтийн дүнгээрээ 52 орчим хувиар өнгөрсөн жилтэй харьцуулахад буурсан. Үүнд эргэн төлөлт хойшлуулсан нь нөлөөлж байна. Хоёрдугаарт, өнгөрсөн жил 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн. Энэ оны хувьд эдийн засгийн нөхцөл байдал, санхүүжилтийн хэмжээтэй уялдаад бага зэрэг буурсан.

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

Өнгөрсөн жил 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн учраас хуучнаасаа нэлээд өндөр нэмэгдсэн. Харин одоо буруу ч хуучин түвшиндээ хүрээд байна.

Үүнээс гадна нэг нөлөөлөл нь банкууд 40 хувийг нь санхүүжүүлдэг. Одоогийн нөхцөл байдлаас үзэхэд банкны олгож байгаа зээл 6 хувьтай байгаа бол бодлогын хүү 10 хувьд хүрснээр банкны харилцах, хадгаламжийн хүү өссөн байгаа. Тэгэхээр 6 хувиар зээл гаргах нь банканд ашиггүй байна гэсэн үг. Тийм ч учраас банкуудаас санхүүжилтийн 40/60-ын харьцаагаа өөрчилж өгөөч ээ гэсэн хүсэлтүүд ирэх болсон. Анх ипотекийн зээлийн хөтөлбөрийг нэвтрүүлэхэд 90/10 байсан. Зургаан хувийн зээлийг нэвтрүүлэхдээ 60/40 болгосон. Тэр үед хүү ч нэлээд боломжийн буусан. Одоо эргээд өссөн байгаа учраас банкны хувьд алдагдалтай байх нь аргагүй. Тиймээс 80/20 байж болох тооцооллыг хийгээд байна. Хэрвээ ингэж өөрчилбөл, банкны эх үүсвэрийн олголт арай идэвхжих боломжтой гэж харж байна. Үүний тулд банкуудтай хийсэн ерөнхий гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай болно.

Найман хувийн ипотекийн зээлтэй иргэд зургаан хувь руу оруулах талаар хүсэлт тавьдаг. Энэ талаар тооцоо судалгаа байдаг уу, боломжтой юу?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

Америкт ипотекийн зээлийн хүү 5.7 хувь болсон. Бараг манай 6 хувьтай адилхан шахуу болчихсон. Тэгэхээр 6 болон 8 хувийн хүүтэй ипотекийн зээл нь бусад зээлийн хүүгээс хамаагүй бага бөгөөд хөнгөлөлттэй хүүтэй хөтөлбөрийн зээл юм. Нэгэнт хөнгөлөлттэй хүүг дахиж доошоо буулгана гэвэл түүний зөрүүг хэн нэгэн нь үүрэх ёстой болно. Гэтэл Монголбанканд тийм боломж байхгүй. Хэрвээ дахин бууруулна гэж үзэх юм бол татаасаар шийдэх үү, эсвэл өөр хэн нэгэн нь даах хэрэг гарна. Найман хувийн зээл авсан хүн 15 жилээр авчихсан, 8 жил төлөөд, одоо 7 жил үлдчихсэн байгаа гээд бодъё. Зургаан хувийн хүүтэй зээл өнгөрсөн оны арваннэгдүгээр сараас олгогдож эхэлсэн. Түүнээс өмнөх бүх зээл 8 хувь байгаа шүү дээ. Нийт хэдэн хүн байна вэ, хэчнээн хэмжээний зардал гарах вэ гэдэг тооцооллыг бид хийж үзсэн. Ингэхээр 400 тэрбум төгрөгийн зардал гарах юм билээ. Энэ зөрүүг хэрвээ улсын төсөв дээр тавьж өгвөл, дахиад л татвар төлөгчдийн мөнгөөр төлөх асуудал яригдана шүү дээ. Зээл авсан

хүний хүүгийн зөрүүг татвар төлөгч миний мөнгөөр төлөх гээд байна уу гэдэг асуудал хөндөгдөвөл хэр нийцтэй вэ? Хэрвээ үүнийг МИК дээр үүрүүлнэ гэвэл бас даахааргүй байгаа юм. Эрсдэлийн санг 0.6 хувиар үүсгэдэг гэхээр 2 хувийн буюу гурав дахин өндөр зардлыг даах боломжгүй. Гэхдээ 400 тэрбум төгрөгөөр бодож, үлдсэн хугацаанд нь жил жилд нь хуваагаад өгвөл дунджаар 10 жил үлдсэн гэж үзээд жилд 40 тэрбум төгрөг л гарна. 40 тэрбумыг улсын төсвийн аль нэг хэсэгт нь үүрүүлж гэвэл бүр огт боломжгүй ч зүйл биш.

Ханшийн тухайд төлбөрийн тэнцлийн алдагдлыг та дурдаж байна. Хамгийн ойрын хугацаанд төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, экспортыг сайжруулах ямар боломж байна вэ, нүүрсний тухайд хэдийгээр экспортын хэмжээ нь нэмэгдэж байгаа ч ихэвчлэн урьдчилаад мөнгөө авчихсан нүүрс л гарч байгаа юм билээ, яг валют орж ирж байгаа нүүрсний экспорт маш бага байна гэдэг мэдээлэл бий. Тэгэхээр ойрын хугацаанд экспортоос орж ирэх боломжтой юу?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

Эрдэнэт үйлдвэр жилдээ 700-аад сая ам.долларын л орлоготой байдаг. Оюутолгойнх мөн ойролцоо. Гүний уурхай нь ирэх жилийн эхний хагаст ашиглалтад орвол баяжмалын агуулга нь сайн гарах учраас тэр үед л орлого нь нэмэгдэж орж ирэх болов уу. Харин 2022 оны хувьд Эрдэнэтээс илүү зүйл хүлээх хэрэггүй. Оюутолгой болон Монголбанкнаас ч мөн ялгаагүй. Монголбанкны авах алт дунджаар 30 тн-д хүрэхгүй. Төмөрийн хүдэр хамгийн сайндаа л 500 сая ам.доллар хүрнэ. Тэгэхээр асуудал нь тээврийн асуудлаа шийдээд, нүүрсээ л ахиухан экспортлоход байна. Нүүрсний экспортоо 36 сая тоннд хүргэчихвэл одоогийн орлого хоёр дахин өсөх боломжтой.

Төлбөрийн тэнцэл энэ хэвээр алдагдалтай яваад байвал одоогийн гадаад валютын нөөц хэд хүртэл буурах боломжтой вэ? Буурсан тохиолдолд зээлийн асуудал яригдах уу?

НУСЗЗГ-ын захирал А.Энхжин:

Хэдийгээр төлбөрийн тэнцлийн алдагдал

нэмэгдэх хүлээлттэй байгаа ч орох урсгалаар энэ алдагдлыг нөхөх болов уу гэсэн хүлээлттэй байна. Нөөцийн хувьд одоо байгаа нөөц нь импортын 4 сарын хэрэгцээг хангахуйц байна. Бидний хувьд 3 сараас доош оруулж болохгүй. Энэ төвшнөөс бууруулахгүй. Орох урсгалын хувьд нүүрсний тээвэр дөнгөж, 5, 6 дугаар сараас л хэвийн голдиролдоо орж байна. Бид 1-2 сарын хугацааны үр дүнг хараад нөхцөл байдлыг дандаа муу байх юм шиг харж болохгүй. Тэгэхээр он дуустал тээвэр хэвийн явбал, нүүрснээс 1-1.2 тэрбум ам.долларын орох урсгал бий болох болов уу. Засгийн газраас саяхан АХБ-наас 100 сая ам.долларын төсвийн дэмжлэгийн зээл авсан. Үүн дээр нэмэгдээд 300 орчим сая ам.долларын зээл орж ирнэ гэсэн хүлээлт байна. Банкууд 250-300 сая ам.долларын зээл авах хэлэлцээр хийж байгаа юм билээ. Ингээд үзэхээр бидний орох урсгал төлбөрийн тэнцлийн алдагдлыг нөхөх боломжтой байгаа юм. Гэхдээ энэ юунаас хамаарах вэ гэвэл Хятадын ковидын асуудал. Нүүрсний тээврийг хэвийн явуулах уу, үгүй юу гэдэг л асуудал байна. Энэ бол том эрсдэл.

Төгрөгийн ханш суларч байгаа нь импортын зардлыг нэмэгдүүлэх, улмаар инфляцын дарамтыг бий болгоно шүү дээ. Ханшийн өнөөгийн суларсан байдал импортын үнэд хэрхэн нөлөөлж байна вэ?

МБГ-ын захирал Б.Баярдаваа:

Ханшийн хувьд төгрөг худалдааны түнш бусад улсуудын валютын эсрэг тухайлбал, АНУ-ын долларын эсрэг 11 хувиар суларсан байна. Гэтэл нөгөө талд Солонгосын вонны эсрэг 2 хувь чангарчээ. Тайландын баттын эсрэг 1 хувиар, Чехийн кроны эсрэг мөн 1 хувиар чангарсан байна. Японы иенийн эсрэг 8 хувиар, Унгарын форинтын эсрэг 14 хувиар чангарсан байна. Жилийн өмнөхтэй харьцуулахад ийм байна. Зарим валютын эсрэг суларсан ч гэсэн, зарим валютын эсрэг чангарсан байна. Үүний цаад шалтгаан юу вэ гэхээр улс орон болгон долларын эсрэг валютаа хэр хэмжээгээр сулруулж байна вэ гэдэг бодлогын асуудал юм. Энэ бол бодлогын сонголтууд юм. Энэ бүхнийг тооцоод үзэхээр долларын эсрэг 11 хувийн сулралт нь худалдааны

түнш орнуудтай харьцуулахад хамаагүй бага гарч байгаа юм. Хоёрдугаарт, ханшийн сулралтыг дагаад мэдээж импорт дээр ачаалал ирсэн. Ингэхээс ч өөр арга байхгүй. Валютын орох урсгал дарамттай байгаа үед импортыг тодорхой хэмжээнд чангалж байж, валютын гарах урсгалаа багасгаж, нөөцөө хэмнэнэ. Мөнгөний бодлого, төсвийн бодлого чангарч байгаагийн үр дүнд импортод суурилсан эдийн засгийн хувьд импортын хэрэглээг нь хоргодуулна. Энэ нь өөрөө тэнцвэржүүлэх ач холбогдолтой.

Удахгүй төсвийн төсөл өргөн баригдана. Төсөв талаасаа бодлогын орон зайг хэрхэн харж байна вэ? Алдагдал тэд орчимд байхад, мөнгөний бодлого дээр тохируулга хийх орон зай хангалттай байхаар байна гэдэг тооцоолол байна уу, Засгийн газарт ямар нэгэн зөвлөмж өгч байгаа юу?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

Бидний хувьд 2023 оны төсөв маш даруухан байх болов уу гэсэн итгэлтэй байна. Сүүлийн гурван жилийн алдагдлын нийлбэр бараг 8 тэрбум ам.долларт хүрчихсэн. Энэ их алдагдал нөхөгдөөгүй. Үүнийг зээлээр санхүүжүүлэх, эсвэл тогтворжуулах шаардлагатай. Төрийн сангийн нэгдсэн санд байгаа ирээдүйн өв сан, нийгмийн даатгалын сан гээд олон сангуудаас авч ашигласан. Одоо энэ сангуудаа нөхөх ёстой. Хүнээр бодвол би маш их өр тавьчихсан, одоо дахиж өр авах боломж байхгүй, дахиж надад зээлэх хүн ч олдохгүй, ийм л байдалтай байна гэсэн үг. Тийм учраас 2023 оны төсөв бараг алдагдалгүй шахуу, тааламжтай төсөв орж ирэх болов уу гэсэн хүлээлттэй байна.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

(2022.08 сар)

ИНФЛЯЦ (ҮСХ хэрэглээний бүтээгдэхүүний үнийн сагсан дахь бараа үйлчилгээгээ шинэчилж, 2020 оныг суурь он болгон хэрэглээний үнийн индексийг шинэчлэн тооцооллоо.)



Бодлогын хүүг 2022 оны 9-р сард 2.0 нэгж хувиар өсгөж 12.0 хувьд хүргэв.



Эх сурвалж: Монголбанк

2022 оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд жилийн инфляц 14.4 хувьтай гарав.



ХҮНСНИЙ ҮНИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ УЛААНБААТАР ХОТ



Мах, махан
бүтээгдэхүүн
5.0%



Сүү, сүүн
бүтээгдэхүүн
29.7%



Төрөл бүрийн
өөх, тос
77.9%



Хүнсний ногоо
41.0%



Талх, гурил,
будгаа
24.5%




Сахар, жимсний чанамал,
чихэр, шоколад
24.7%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


M2 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ



M2 мөнгөний нийлүүлэлт 2022 оны 8 дугаар сард 26.9 их наяд ₮ хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7% -иар буурав.



M2-ийн өсөлт байршуулалт талаас



M2-ийн өсөлт эх үүсвэр талаас




Эх сурвалж: Монголбанк


ЗЭЭЛ



Банкнудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 14.6%-иар өсч 22.6 их наяд төгрөгт хүрэв.



Банкуудын чанаргүй зээл нийт зээлийн үлдэгдлийн 11.1%-ийг бүрдүүлж байна.



Зээлийн жилийн өсөлт, салбарын ангиллаар




Эх сурвалж: Монголбанк


ИПОТЕКИЙН ЗЭЭЛ




Ипотекийн нийт зээлийн үлдэгдэл **6,112.5** тэрбум төгрөгт хүрэв.



Шинээр олгосон ипотекийн зээлийн хүү



Зээлдэгчдийн тоо




Эх сурвалж: Монголбанк

ХҮҮ



Шинээр олгосон төгрөгийн зээлийн дийлэнх хувь нь **12-оос 16 хувийн** хүүтэйгээр олгогджээ.



Шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү, **салбарын** ангиллаар




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ



Төлбөрийн тэнцлийн динамик, сая ам.доллар




МУ-ын төлбөрийн тэнцэл 2022 оны эхний 7 сарын урьдчилсан байдлаар **1,317** сая ам.долларын алдагдалтай гарсан.



Урсгал ба хөрөнгийн дансны бүтэц



Санхүүгийн дансны бүтэц



Эх сурвалж: Монголбанк

ТӨВ БАНКУУДЫН БОДЛОГЫН ХҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ



М.БУЯНБИЛЭГ
(Мөнгөний бодлогын
газрын эдийн засагч)




Г.МӨНХБАЯР
(Мөнгөний бодлогын
газрын эдийн засагч)

2020 онд цар тахлын үед дэлхийн төв банкууд санхүүгийн нөхцөлийг зөөлрүүлэх, эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг бууруулах, хөрөнгийн худалдан авалт хийх зэрэг төрөл бүрийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсэн. Харин өнгөрсөн оны эхнээс цар тахлаас үүдэлтэй тээвэр логистикийн саатал, нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжлэн зардлын инфляц нэмэгдэн, нөгөө талаар эдийн засгийн идэвхжил сэргэж эхэлсэнтэй холбоотойгоор зарим улсын төв банк бодлогын хүүгээ өсгөж эхэлсэн бөгөөд 2021 онд нийт 136 бодлогын шийдвэрээс 120 нь бодлогын

хүүг өсгөх шийдвэр гаргажээ. Энэ оны эхнээс Орос, Украины нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхий нийтээр хүнс болон шатахууны үнийн өсөлт эрчимжиж байгаа нь төв банкууд бодлогын хүүгээ илүү эрчимтэйгээр өсгөх гол шалтгаан болж байна. Улмаар, 2022 оны 8 дугаар сарын байдлаар нийт 71 улсын төв банк 254 удаа бодлогын хүүгээ өөрчлөх шийдвэр гаргасны 244 нь бодлогын хүүг нэмэгдүүлжээ (Зураг 1). Харин, ОХУ, Узбекистан, Хятад, Турк зэрэг улсын төв банкууд 10 удаагийн шийдвэрээр бодлогын хүүгээ сулруулсан байна.

Зураг 1. Төв банкуудын бодлогын хүүгээ өөрчилсөн шийдвэрийн тоо, 2020.I-2022.III



*08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар


Эх сурвалж: Central Bank News

Энэ оны эхнээс төв банкуудын бодлогын хүүний түвшин хэр зэрэг өөрчлөгдсөнийг Зураг 2-т дүрслэв. Бодлогын хүүгээ 1 хүртлэх нэгж хувиар өөрчилсөн 14 улсын төв банк байгаа бол 3 улсын төв банкны бодлогын хүүний түвшин оны эхнээс буурчээ. Харин бодлогын хүүгээ 1.0 нэгжээс дээш хувиар өсгөсөн 54 улсын төв банк байна. Тодруулбал, бодлогын хүүгээ 2-4 нэгж болон 4 нэгжээс дээш хувиар өсгөсөн тус бүр 15 улсын төв банк байна. Монголбанкны хувьд энэ онд гурван удаагийн Мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүг 4.0 нэгж хувиар нэмэгдүүлж 10.0 хувьд хүргэсэн. Төв банкуудын бодлогын хүүний нийт өөрчлөлтийн хэмжээг

улсуудын орлогын ангиллаар авч үзэхэд харьцангуй жигд буюу бүх ангиллын хувьд их, бага хэмжээгээр бодлогын төлөвөө чангаруулсан байна. Эдгээрээс, бодлогын хүүгээ 4 нэгжээс дээш хувиар өсгөсөн улсуудыг дурдвал

- 1) Бага болон дундаас доогуур орлоготой – Шри Ланка, Гана, Киргиз, Украин, Пакистан
- 2) Дундаас дээгүүр орлоготой – Аргентин, Молдав, Коста Рика, Колумб, Бразил, Казахстан
- 3) Өндөр орлоготой – Унгар, Польш, Чили, Уругвай зэрэг улсууд багтаж байна.

Зураг 2. 2022 оны төв банкуудын бодлогын хүүний нийт өөрчлөлтийн хэмжээ*, орлогын ангиллаар




*08 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар

Эх сурвалж: Central Bank Rates

Дэлхийн улс орнуудыг орлогоор нь ангилан 2019 оны сүүлийн байдлаар буюу цар тахлаас өмнөх үеийн бодлогын хүүний түвшин болон 2022 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар бодлогын хүүний түвшинг Зураг 3-т дүрслэв. Эдгээр 142 улсын 68 улсын хувьд өнөөгийн бодлогын хүү нь 2019 оны түвшнээс бага байгаа бол 55 нь цар тахлын өмнөх үеэс өндөр, үлдсэн 19 улсын хувьд одоогийн бодлогын хүү нь цар тахлын өмнөх үеийн түвшинд байна. Бага болон дундаас доогуур орлоготой орнуудын бодлогын хүү

нь дунджаар цар тахлын өмнөх үеийн түвшинд байгаа бол өндөр орлоготой 34 улсын хувьд одоогийн бодлогын хүү нь цар тахлаас өмнөх үеэс дунджаар 1.0 нэгж хувиар өндөр, дундаас дээгүүр орлоготой 41 улсын хувьд дунджаар 1.5 нэгжээр өндөр байна. 2019 оны байдлаар бодлогын хүү нь харьцангуй бага түвшинд байсан улсуудын бодлогын хүү өмнөхөөсөө илүү өндөр болсон хандлагатай байна.

Зураг 3. Дэлхийн улсуудын 2019 он болон 2022 оны бодлогын хүүний түвшин




Тэмдэглэл: ANG-Ангол; ARM-Армен; AUS-Австрали; BEL-Беларусь; BAR-Барбадос; BOTS-Ботсвана; BRAZ-Бразил; BRU-Бруней; BRD-Бурунди; BRUK-Буркина Фасо; CAM-Камбож; CAN-Канад; CHI-Чили; COL-Колумб; CON-Конго; CZE-Чех; ECU-Эквадор; EGY-Египет; GAM-Гамби; GEO-Гүрж; GHA-Гана; HAI-Гаити; HUN-Унгар; ICE-Исланд; JAM-Ямайка; KUW-Япон; KAZ-Казахстан; KYR-Киргиз; LEB-Ливан; MAC-Макао; MOL-Молдав; MOZ-Мозамбик; MYAN-Мьянмар; NAM-Намиби; NEP-Непал; NEW-Шинэ Зеланд; NIG-Нигери; PER-Перу; PHIL-Филиппин; POL-Польш; QAT-Катар; RUS-Орос; SOU-Өмнөд Судан; SRI-Шри Ланка; SUD-Судан; SWI-Швейцарь; TAJ-Тажикстан; THAI-Тайланд; TRI-Тринидад Тобаго; TUR-Турк; UGA-Уганда; UKR-Украин; UK -Их Британи; USA-АНУ; YEM-Йемен; ZAM-Замби

Эх сурвалж: Central Bank Rates & Centralbankinfo

Энэ оны эхнээс бодлогын хүүгээ өөрчлөх шийдвэр гаргасан төв банкуудын бодлогын хүүг тухайн улсын 2022 оны 7 дугаар сарын инфляцын түвшин болон инфляцын зорилтын дээд хязгаартай харьцуулан Зураг 4-т харуулав. Ихэнх улсад инфляцын түвшин

нь төв банкны зорилтод түвшнээс давсан байгаа бөгөөд дунджаар 7 орчим хувиар илүү, дийлэнх улсад инфляцын түвшин нь бодлогын хүүнээс өндөр буюу бодит хүү сөрөг байна.

Зураг 4. 2022 онд бодлогын хүүгээ өөрчилсөн улсуудын голлох үзүүлэлтүүд



Эх сурвалж: Төв банкуудын цахим хуудас, Central Bank Rates

Бодлогын хүүгээ өсгөсөн улсуудын мөнгөний бодлогын мэдэгдэлд голлох үндэслэл, шалтгаануудыг онцлохдоо Инфляц зорилтот түвшнээс давж өссөн бөгөөд цаашид тодорхой хугацаанд өндөр түвшинд хадгалагдах хүлээлттэй байна (Зураг 4). Ийнхүү инфляц өндөр түвшинд байгаа мөн үргэлжлэн нэмэгдэх эрсдэл (upside risk) ихэнх улсуудад давамгайлж байгаа нь бодлогын хүүг өсгөх гол шалтгаан болж байна. Нийлүүлэлтийн сүлжээний доголдол болон Орос, Украины нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн зах зээл дээрх эрчим хүч, түүхий эдийн үнэ үргэлжлэн өснө гэсэн хүлээлтэд үндэслэн инфляцын дарамтаа нэмэгдэнэ гэж үзжээ. Мөн дэлхийн эдийн засгийн идэвхжилд ихээхэн хүндрэлийг үүсгэж байна. Түүнчлэн БНХАУ-д цар тахалтай холбоотой хөл хорио нь дэлхийн эдийн

засгийн төлөв болон нийлүүлэлтийн сүлжээний доголдолд сөргөөр нөлөөлж байна. Мөн АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ шат дараатай өсгөж, ам.долларын өгөөжийг нэмэгдүүлснээр бусад улсын валютын ханш суларч байна. Үүнээс шалтгаалан импортын инфляц нэмэгдэж, инфляцын дарамтыг улам өдөөж байна. Зарим улсуудын хувьд хөдөлмөрийн зах зээл сэргэсэн, эдийн засгийн өсөлт тогтвортой байгаагаас гадна инфляцын түвшин өндөр түвшинд байгаа нь бодлогын хүү өсөх гол шалтгаан болов. Ингэж бодлогын хүүг нэмэгдүүлэх нь инфляцын хүлээлтийг удирдах замаар дунд хугацаанд зорилтод түвшинд тогтворжуулах, эрэлт, нийлүүлэлтийн тогтвортой тэнцвэрийг хангахад чиглэж байна.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

2019-2022 ОНД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ

2019

ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУДЫН ХӨРӨНГИЙН ХУВААРИЛАЛТ

Мөнгөний статистик, төсвийн гүйцэтгэл, төлбөрийн тэнцлийн статистик болон үндэсний тооцооны статистик мэдээлэл ашиглан Монгол Улсын сектор хоорондох хөрөнгийн урсгалын матрицыг 2018 оны байдлаар гаргасан.

УЛИРЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ ХЭМЖИХ АСУУДЛУУД

Монгол Улсын баяр, амралтын өдрүүдийн тусгай тохиргоотойгоор календарийн хүчин зүйлсийн нөлөөллийг судалгаа шинжилгээнд түлхүү хэрэглэгддэг тоон өгөгдлүүдийн хувьд шалгаж үр дүнг харуулсан.

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Төсвийн тэнцэл ба бодит валютын ханш хоёрын хоорондын харилцан хамаарлыг 2000-2020 оны тоон мэдээлэл дээр тулгуурлан судалж цаашид эдгээр асуудлуудын хүрээнд авч хэрэгжүүлэх санал боловсруулсан.

УУЛ УУРХАЙН БУС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТООН МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2010 – 2019 оны хооронд Монгол улсын хилээр гадагш гарсан бүтээгдэхүүний тоон мэдээг МУ-ын Гаалийн ерөнхий газраас авч боловсруулан, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих чиглэлээр санал, дүгнэлтүүдийг боловсруулсан.

2020

ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТИЙН АРГАМЖАА, ТҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Инфляцын аргамжааг тайлбарлах, түүнийг тодорхойлох олон улсын туршлага, арга зүй, Монгол Улсад хэрхэн авч үзэж болох талаар судалж, саналболовсруулсан.

ЦАР ТАХАЛ БА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЕКТОР

Коронавируст цар тахлын эдийн засаг, тэр дундаа үйлчилгээний секторт үзүүлжбуйнөлөө,авчхэрэгжүүлжбуй арга хэмжээг нэгтгэн судалсан.

2021

ОРЧИН ҮЕИЙН АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГО БА НОГООН ЭДИЙН ЗАСАГ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Орчин үеийн аж үйлдвэржилтийн бодлого, аж үйлдвэржилтийн хөгжлийн чиг хандлага болон олон улсын туршлагыг судалж, манай орны хувьд авч хэрэгжүүлэхэд тохиромжтой шийдлүүдийг санал болгосон.

УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТЫН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, АРГА ХЭРЭГСЛҮҮД

Экспортыг дэмжих бодлого, экспортын санхүүжилтийн арга хэрэгслүүд, холбогдох асуудлуудыг хариуцдаг институциудын талаарх олон улсын туршлага, үр дүнгийн талаар судалж, Монгол Улсын уул уурхайн бус экспортыг дэмжих төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай санал зөвлөмжүүдийг боловсруулж байна.

2022

Энэ буландаа Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн үйл ажиллагааны тухай танилцуулж байна.

Монголбанкны Эдийн Засгийн Судалгаа, Сургалтын Хүрээлэн нь Монгол Улсын хөгжил, эдийн засаг болон санхүүгийн салбар дахь бодлогын шийдвэрүүдэд дэмжлэг болохуйц өргөн хүрээний суурь судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэх, төрийн албан хаагчид болон санхүүгийн салбарын мэргэжилтнүүдэд дунд болон ахисан түвшний сургалт явуулах зорилготойгоор 2018 онд байгуулагдсан.

ЭЗССХ-ийн хийж гүйцэтгэж буй судалгааны ажлууд нь гадаад, дотоод эдийн засгийн орчин, эдийн засгийн өсөлт, төсвийн бодлого, санхүүгийн зах зээл, нийгмийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл, аж үйлдвэрлэл, хөдөө, аж ахуй, байгалийн баялаг зэрэг макро эдийн засгийн өргөн хүрээг хамардгаараа бусад судалгааны чиг үүрэг бүхий газруудаас ялгагддаг. Тухайлбал, малчин өрхийн аж байдлыг үнэлэх, төсвийн давамгайлал, уул уурхайн бус экспортыг хөгжүүлэх, ногоон эдийн засаг, аж үйлдвэрлэл, Монгол Улсын дундаж давхаргыг тодорхойлох зэрэг сэдвийн хүрээнд судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Төрийн албан хаагчид болон бусад санхүүгийн салбарын мэргэжилтнүүдэд ахисан түвшний сургалт зохион байгуулах чиг үүргийн дагуу банкны ажилтны семинар, удирдах ажилтны семинар, шинэ ажилтны чиглүүлэх сургалт, орон нутгийн ажилтнуудад зориулсан сургалт зэрэг сургалтуудыг батлагдсан хөтөлбөрүүдийн дагуу Монголбанкны бусад газар нэгжүүд болон гадны байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулдаг. Сургалтыг зохион байгуулахдаа арилжааны банкууд, Монголбанкны газар, нэгжүүд орон нутгийн салбарын ажилтнуудаас сургалтын сэдвийн саналыг авч, шаардлагатай сургалтын хөтөлбөрийг боловсруулан ажилладаг.

Тус хүрээлэнгийн тогтмол зохион байгуулдаг сургалтууд:

- Банкны ажилтны семинар: Монголбанкнаас гаргасан бодлого, журамтай уялдуулан ажиллах, банкууд нэг стандарт жишгийн дагуу

үйл ажиллагаа явуулах, олон улсын банк санхүүгийн салбарын чиг хандлагыг судлах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зэрэг зорилгын хүрээнд Монголбанкны бусад газар нэгж болон бусад байгууллагуудтай хамтран арилжааны банкны мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, мэдээлэл өгөх зорилготой цахим сургалт

- Шинэ Ажилтны чиглүүлэх сургалт: Монголбанкны шинэ ажилтнуудад төв банкны үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, чиглүүлэх зорилготой сургалтыг Тамгын газартай хамтран зохион байгуулдаг.
- Удирдах ажилтны семинар: Орон нутаг дахь Монголбанкны хэлтэс, салбарын удирдах ажилтнуудад холбогдох байгууллагуудтай хамтран сургалт, семинар зохион байгуулдаг.
- Монголбанкны сургалтын нэгдсэн модуль: Сургалтын модульд Монголбанкны төв болон орон нутгийн салбар хэлтсийн ажилтнуудаас гадна арилжааны банкны шийдвэр гаргах, удирдах, мэргэжилтний түвшний сургалтууд, мөн бодлого боловсруулагчдад зориулсан сургалт зэргийг зохион байгуулдаг.

Судалгаа шинжилгээний үр дүнд үндэслэн бодлогын санал, зөвлөмжүүд боловсруулах, холбогдох газруудад хүргүүлж ажилладаг ба зөвшөөрөгдсөн судалгааны ажлыг илтгэл хэлбэрээр хурал зөвлөгөөнд танилцуулах, төрийн бусад байгууллага, агентлагуудтай хамтран бодлогын форум, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулдаг. Тухайлбал, "Үндэсний тооцооны систем-2018", "Өрхийн хэрэглээ санхүүгийн байдал", "Зээлийн хүүг бууруулах арга замууд" гэх мэт хурал хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан ба

Төрийн албан хаагчид, бүх түвшний мэргэжилтнүүд, олон нийтэд эдийн засгийг энгийнээр ойлгуулах, бодлогын судалгаа, түүнд тулгуурласан саналуудыг уншиж ойлгоход түлхэц үзүүлэх зорилгоор "Эдийн Засгийг Энгийнээр" сэтгүүлийг хагас жил тутам эрхлэн гаргаж байна. Түүнчлэн, инфляц болон ханшийн түүхэн тоо мэдээлэлд үндэслэн сар бүрийн инфляцын шинж тэмдэг бүхий календарийг тогтмол нийтэлдэг.



ДУРСГАЛЫН

Зоосны тухай

Монголбанк буюу хуучнаар Улсын банк 1971 онд Ардын хувьсгалын 50 жилийн ойд тохиолдуулан нэг төгрөгийн нэрлэсэн үнэтэй алт, мөнгө, гууль, никель дурсгалын зоосыг анх гаргаж байв. Үүнээс хойш Монголбанк хүн төрөлхтний болон өөрийн орны түүхэн тэмдэглэлт ой, түүхт хүмүүс, соёлын өв, онцлог үйл явдал, соёл урлаг, спортын амжилтад зориулан олон төрлийн дурсгалын зоос гаргаснаа эдүгээ 50 жил болжээ.


Монголбанкнаас гаргаж буй дурсгалын зоос нь нэрлэсэн үнэ, Монголбанкны лого тэмдэгтэй байдаг. Сүүлийн үед техник технологийн хөгжил дэвшил, урлан бүтээгчдийн ур чадвартай уялдан, загвар, үзэмж нь жилээс жилд сайжирч, ур хийцийн хувьд дэлхийд өрсөлдөхүйц түвшинд хүрч буй.

Дурсгалын зоос нь нэг сэдвийн хүрээнд цувралаар үйлдвэрлэгддэг бөгөөд 2020 онд гаргасан “Majestic eagle” цуврал дурсгалын зоос нь хамгийн сүүлийн

үеийн технологи болох “smartminting” технологиор хийгдэж, Берлиний Дэлхийн мөнгөний үзэсгэлэнд анх танилцуулагдсан ховор зоос юм. Уг дурсгалын зоосны 2 талыг “smartminting” буюу товойлгох технологиор хийсэн тул нүүрэн талын бүргэдийн сарвууны хэсэг, ар талын бүргэдийн толгой хэсэг нь товгор, илүү шинэлэг өвөрмөц байдалтай үйлдвэрлэгдсэн юм.

“Majestic eagle” дурсгалын зоос нь 2020 онд 1 унцийн алт, 1/10 унцийн алт, 1, 2, болон 3 унцийн мөнгө, мөн 50 грамм зэс гэсэн 6 төрлийн хэмжээтэй гарч, 2021 онд 1 кг мөнгөн зоосыг худалдаанд гаргасан.

Дурсгалын мөнгөн зоосны мэдээллүүд нь coin.mongolbank.mn сайтад мэдээлэгдэж байна.



JACKSON HOLE ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨГӨӨН: ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН БОДЛОГЫН ХЯЗГААРЛАЛТУУДЫГ ДАХИН ҮНЭЛЭХ НЬ

Дэлхийн томоохон төв банкууд, олон улсын байгууллагууд оролцдог “Jackson Hole Эдийн Засгийн Бодлогын Зөвлөгөөн” АНУ-ын Миссури мужийн Канзас хотноо 2022 оны 8-р сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан билээ. Энэхүү зөвлөгөөн дээр дээд түвшний бодлого боловсруулагчид цар тахлын дараа эдийн засаг болон макро бодлогуудад тулгарч буй сорилтууд, хязгаарлалтууд, тэдгээрийг хэрхэн шийдэх шийдлийн талаар санал солилцсон бөгөөд зөвлөгөөний үеэр хэлэлцсэн судалгааны ажлууд, онцлох илтгэлүүдийг цувралаар толилуулахаар зэхлээ. Энэ удаад бид тус зөвлөгөөнөөр хэлэлцсэн асуудлуудыг тоймлон танилцуулж байна.

1. ЭДИЙН ЗАСГИЙН ХЯЗГААРЛАЛТУУДЫГ ДАХИН ҮНЭЛЭХ НЬ

Потенциал үйлдвэрлэл: Цар тахлын эдийн засгийн потенциал үйлдвэрлэлд үзүүлсэн нөлөөг авч үзвэл хөл хорионоос үүдэлтэй хөдөлмөрийн нийлүүлэлтийн бууралт потенциал үйлдвэрлэлийн түвшин буурахад голлон нөлөөлжээ. Цар тахлын үеийн өөрчлөлтүүд богино хугацаанд эдийн засгийн бүтээмжид эерэг,сөрөг нөлөө үзүүлсэн бөгөөд хөдөлмөр болон капиталд үзүүлэх урт хугацааны нөлөө одоогоор тодорхойгүй байна. Хөдөлмөрийн зах зээлийн хувьд зайнаас ажиллах боломж бүрдсэн учир хүүхэд, өндөр настнуудыг асарч буй хүмүүс

хөдөлмөрийн зах зээлд орох боломжтой ч цар тахлын үед сургуульд хамрагдалт буурсан тул ирээдүйн хөдөлмөрийн нийлүүлэлт буурах магадлалтай байна. Харин капиталын хувьд Засгийн газрын өр нэмэгдсэн нь нэг талаас урт хугацааны капиталын хөрөнгө оруулалт болон потенциал үйлдвэрлэлийг бууруулж байна. Гэвч нөгөө талаас, цар тахлын үед хуримтлагдсан хадгаламж нь илүү их капиталын өсөлтийг бий болгож, Засгийн газрын өрөөс үүдэлтэй нөлөөг нөхөх боломжтой. Мөн үйлдвэрлэгчид цар тахалтай ижил төрлийн эрсдэлүүдээс зайлсхийх зорилгоор хөдөлмөрийг капиталаар орлуулах

боломжтой ба энэ нь потенциал үйлдвэрлэлийг өсгөнө (John Fernald, Huiyu Li).

Бүрэн ажил эрхлэлт:

Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, ирээдүйд ажиллах хүчний нийлүүлэлт, потенциал үйлдвэрлэлээ төлөвлөхдөө нэг ажилчинд ногдох цагийг ажил эрхлэлтээс дутуугүй анхаарах шаардлагатай байна. Ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ гэдэг нь нийт ажиллах цагийг нэмэгдүүлнэ гэсэн үг биш бөгөөд ажил эрхлэлтийн түвшин хамгийн их өсөлттэй байсан улсуудын нэг ажилтанд ногдох цаг буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг ажлын тогтмол зардлыг бууруулснаар ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж, нэг ажилчинд ногдох цаг буурч байгаагаар тайлбарлаж болно. Ажлын тогтмол зардал буурах хандлага цар тахлын үеийн нөлөөгөөр (гэрээсээ ажиллах болсон, ажлын уян хатан цагийн зохицуулалт гэх мэт) цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна. Энэ хүрээнд бодлого боловсруулагчид ажлын тогтмол зардалд нөлөөлж буй хүчин зүйлс, ажлын тогтмол зардал цаашид буурснаар үүсч болох нөлөөллийг тодорхойлох, энэ нь хөдөлмөрийн бизнесийн мөчлөг, мөнгөний бодлого, татварын бодлогын шоконд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхэд анхаарах хэрэгтэй (Nicola Fuchs-Schündeln, Stephanie Aaronson).

2. БОДЛОГЫН ХЯЗГААРЛАЛТУУДЫГ ДАХИН ҮНЭЛЭХ НЬ

Мөнгөний бодлого: Олон улсад 30 жилийн турш харьцангуй тогтвортой байсан инфляц сүүлийн нэг жилд огцом өсөж, дэлхий нийтээр инфляцыг хумих сорилттой туллаа. Инфляц өсөх хандлага давамгайлж буй энэ үед эдийн засгийг халалттай чигээр нь явуулах, нийлүүлэлтийн түр зуурын шокыг үл тоох зэрэг бодлогын стратегиудыг эргэн харж, сайжруулах шаардлагатай байна. Түүнчлэн, цар тахал болон геополитикийн эрсдэлүүд удаан хугацаанд үргэлжлэх нь инфляцын хоёр дахь үеийн нөлөө эрчимжих, дунд хугацаанд инфляцын хүлээлт аргамжаанаас гарч, инфляц өндөр түвшинд дагуулна. Иймд төв банкны зүгээс инфляцыг хумих зохистой бодлогын тохиргоог цаг алдалгүй хэрэгжүүлэх нь зүйтэй (Jason Furman, Gita Gopinath, Valerie A. Ramey).

Тодорхой бус байдал өндөртэй өнөөгийн орчинд төв банкууд чухалчлан авч үзэх хэрэгтэй 4 шинэ өнцгийг санал болгож байна. Үүнд:

1. Төв банк хүлээлтээр дамжуулж ирээдүйд чиглэх (Forward guidance) бодлого хэрэгжүүлэхээс илүүтэй инфляцыг зорилтот түвшинд хүргэх хүртэл тууштай бодлогын арга хэмжээг авах нь чухал боллоо.

2. Хэвийн үед бодлогын хариу үйлдэл алгуур байхыг чухалчилдаг бол одоогийн нөхцөлд мөнгөний бодлогын хариу үйлдэл хурдан байхгүй тохиолдолд инфляцын хүлээлт өсөх эрсдэлтэй бөгөөд төв банк эдийн засгийг хэвийн байдалд авчрахын тулд бодлогын хүүг илүү огцом өсгөхөөс аргагүйд хүрнэ.

3. Төв банкны хариу үйлдэл өнөөг хүртэл таамаглах боломжтой, гэнэтийн шийдвэр багатай байлаа. Харин эдийн засагт тодорхой бус байдал ихтэй, инфляц өндөр түвшинд удаан хадгалагдах эрсдэлтэй үед бодлогын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд төв банк шаардлагатай тохиолдолд гэнэтийн шийдвэрүүдийг гаргаж, хариу үйлдэл сайтай (reactive) байх хэрэгтэй болж байна.

4. Нейтраль хүү (R^*) нь мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах эсэхийг тодорхойлоход ач холбогдолтой хэвээр байна.

(Jerome Powell, Francois Villeroy De Galhau)

Төсвийн бодлого: Цар тахлаас үүдсэн эдийн засгийн хямралын эсрэг улс орнууд төсвийн тэлэх бодлого явуулж, төсвийн зардлыг их хэмжээгээр өсгөсөн нь үр ашгаа өгч эдийн засгийн сэргэлтийг хурдасгасан боловч нөгөө талдаа төсвийн шинжтэй

инфляцыг эрс нэмэгдүүлээ. Цар тахлаас өмнө төсвийн шинжтэй дунд зэргийн инфляц нь дефляцын дарамтыг бууруулж, төв банкуудад дефляциас зайлсхийхэд тусалж байв. Харин өнөөгийн нөхцөл байдалд үнийн өсөлтийг дан ганц мөнгөний бодлогоор хумих гэж оролдох нь үр дүн багатай байна. Засгийн газрын өрийг ирээдүйн төсвийн төлөвлөгөөгөөр амжилттай тогтворжуулсан тохиолдолд л төв банк инфляцын түвшинг тогтворжуулж, хяналтдаа авах боломжтой. Түүнчлэн, төсвийн алдагдал нэмэгдэхийн зэрэгцээ төсвийн бодлогод итгэх итгэл сулрах нь инфляцыг төв банкны урт хугацааны зорилтот түвшнээс хазайхад хүргэж болзошгүй. Төсвийн зарцуулалтад тодорхой хязгаарлалт тавихгүйгээр бодлогын хүүг өсгөх нь өрийн санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, улмаар инфляцын хүлээлтийг өсгөх эрсдэлийг дагуулж байна. Өөрөөр хэлбэл, мөнгөний хатуу бодлогыг түүнд тохирсон төсвийн бодлогоор дэмжээгүй тохиолдолд төсвийн тэнцвэргүй байдал инфляцын дарамтыг улам нэмэгдүүлнэ. Үүний үр дүнд нэрлэсэн хүү, инфляц, өрийн хэмжээ нэмэгдэж, эдийн засагт стагфляц явагдсанаар чөтгөрийн тойрогт орох аюултай юм. Иймд цар тахлын дараах инфляцын сорилтыг даван туулахын тулд инфляцын зорилтот түвшин болон өрийн тогтвортой байдлыг хэрхэн хангах талаар харилцан



Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкны ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал Жон С.Уильямс, Холбооны нөөцийн сангийн Захирлуудын зөвлөлийн дэд дарга Лаел Брейнард, Холбооны нөөцийн сангийн тэргүүн Жером Пауэлл нар Тетон үндэсний цэцэрлэгт хүрээлэнд алхаж байна.

уялдаатай төсөв, мөнгөний бодлого шаардлагатай байна (Francesco Bianchi, Leonardo Melosi).


Нийт нийлүүлэлт ба макро тогтвортой байдал:

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд эдийн засаг дахь нийт нийлүүлэлтийг дэмжиж, дэлхий нийтийн нийлүүлэлтийн сүлжээ хөгжихөд нөлөөлсөн тогтвортой геополитикийн орчин, технологийн дэвшил, глобалчлал, хүн амзүйн бүтэц гэсэн үзүүлэлтүүд одоо нийт нийлүүлэлтэд сөрөг чиглэлд нөлөөлж эхэллээ. Иймд төв банкууд тэргүүн ээлжид инфляцыг нам түвшинд тогтворжуулахад анхаарах хэрэгтэй. Төсвийн бодлого байгаа бага орон зайгаа ашиглан уур амьсгалын өөрчлөлт, хүн амын насжилт, дэд бүтэц

зэргээс үүдэлтэй нийлүүлэлтийн хязгаарлалтыг шийдэхэд анхаарах хэрэгтэй байна (Agustin Carstens).

Эх сурвалж: <https://www.kansascityfed.org/research/jackson-hole-economic-policy-symposium-reassessing-constraints-on-the-economy-and-policy/>

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 26/VIII ӨДРИЙН БАЙДЛААР)



МӨНГӨНИЙ БОДЛОГО, ҮНИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



"Jackson Hole Эдийн Засгийн Бодлогын Зөвлөгөөн"-ийг нээж Холбооны Нөөцийн Банкны Тэргүүн Jerome Powell -ийн хэлсэн үгийг бүрэн эхээр нь толилуулж байна.

Холбооны Нөөцийн Банк (ХНБ)-ны өмнө тулгараад буй нэн тэргүүний сорилт нь инфляцыг хумьж, төв банкны зорилтот түвшинд авчрах асуудал болоод байна. Үнийн тогтвортой байдал нь бүрэн ажил эрхлэлт, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих суурь нөхцөл билээ. Тиймээс төв банк инфляцын зорилтыг хангахын тулд ХНБ-ны хүүг удаа дараа өсгөөд байгаа нь богино хугацаанд дотоод эрэлтийг хязгаарлан, хөдөлмөрийн зах зээлийн төлөвийг муутгаж, өрхүүд, ААН-д дарамт учруулж байна. Гэвч энэ бол инфляцыг хумих зайлшгүй зардал юм. Хэрвээ үнийг тогтвортой түвшинд хадгалж чадахгүй бол иргэдийн бодит худалдан авах чадвар, амьжиргааны түвшин доройтож, үүнээс илүү урт хугацааны хохиролтой нүүр тулах болно.

ХНБ-наас эдийн засаг, инфляцын ирээдүйн төлөвт тулгуурлан 2022 оны 7 дугаар сард ХНБ-ны хүүг хоёр дахь удаагаа 0.75 нэгж хувиар өсгөсөн бөгөөд ирэх 9 дүгээр сарын хурлаар дахин том алхмаар хүүгээ өсгөх нь зүйтэй гэж харж байна. Ийнхүү мөнгөний бодлогын төлөвийг тодорхой түвшинд хүртэл чангалсны дараа хүү өсгөх хурдаа сааруулах болно. Учир нь инфляцыг тогтворжуулахын тулд бодлогын хатуу төлөвийг тодорхой хугацаанд хадгалах шаардлагатай. Хэт яарч бодлогын төлөвийг зөөлрүүлснээс алдсан түүх бий.

Төв банк 1970, 1980-аад оны үнийн өндөр өсөлт, сүүлийн хагас зууны нам дор инфляц зэрэг өнгөрсөн хугацааны инфляцын динамикт дүн шинжилгээ хийсний дүнд 3 сургамжийг авах боломжтой байна. Үүнд:

Нэгдүгээрт, Төв банк нам, тогтвортой инфляцын зорилтыг хангахад бодлогоо бүрэн чиглүүлж, хариуцлагатай байх ёстой.

Хоёрдугаарт, олон нийтийн инфляцын талаарх хүлээлт инфляцын ирээдүйн төлөвт чухал нөлөөтэй.

Гуравдугаарт, инфляц тогтворжих хүртэл бодлогын хатуу төлөвийг тууштай барих хэрэгтэй. Тэгэхгүй бол өндөр инфляц цалинг өсгөж, үнэ-цалин-үнэ гэсэн тасралтгүй өсөх циклд орох эрсдэлтэй.

Эдгээр сургамжууд нь ХНБ инфляцыг хумих тууштай арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагатайг бататгаж байна. Бодлогын хүчилсэн, шийдэмгий арга хэмжээний дүнд дотоод эрэлт нийлүүлэлттэйгээ нийцтэй түвшинд бууж ирэх бөгөөд өв банк инфляцын хүлээлтийг аргамжихад туслах болно.

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТЭЙ БОЛЛОО



Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын төрлийн бүс нутгийн байгууллага болох Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн (АНДМУТБ) 25 дахь удаагийн жилийн уулзалт Малайз Улсын Куала Лумпур хотноо 2022 оны 7 дугаар сарын 24-өөс 28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Энэ талаар Санхүүгийн мэдээллийн албаны дарга Б.Батбаатартай ярилцлаа.

Саяхан болсон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн жилийн уулзалт уулзалтын гол үр дүнгээс юунаас өмнө сонирхуулна уу?

Энэ жилийн уулзалтаар Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын хамтран боловсруулсан Монгол Улсын 2022 оны Явцын тайланг хэлэлцэж баталлаа. Хурлаар Монгол Улсын ФАТФ-ын Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулж “Дийлэнхийг биелүүлсэн” гэсэн дүгнэлтэд хүргэсэн. Ингэснээр Монгол Улс ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжөөс 39 зөвлөмжийн үнэлгээг хангаад байна. Мөн Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, бусад гишүүн улс орон болон олон улсын байгууллагуудаас манай улсын үлгэр, жишээ болохуйц ахиц дэвшлийг өндрөөр үнэлсэн. Хурлын үеэр АНДМУТБ-ийн дарга Иан Маккартин Монгол Улсын төлөөллийг хүлээн авч уулзан гаргаж буй ахиц дэвшлийг өндрөөр үнэлж, цаашид үлдэж буй зөвлөмжүүд болон шууд хэрэгжилтийн зөвлөмжүүд дээр түлхүү анхааран ажиллахыг зөвлөсөн. Мөн манай орон Зөвлөмж 15 дээр хангалттай үнэлгээ авсан ФАТФ-ын бус гишүүн улс орнуудаас анхны улс

болсныг онцлон тэмдэглэснийг энд дурдах нь зүйтэй болов уу.

Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн алба хурлын үеэр Камбож болон Зүүн Тимор улсуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Мөн Малайз улсын Санхүүгийн мэдээллийн албатай туршлага солилцож СБМҮҮ салбар дахь хяналт шалгалт, зөвлөмж 8-ийн үнэлгээг ахиулах талаар туршлага судаллаа. Түүнчлэн, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн дэргэдэх олон улсын донор байгууллагууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр үзүүлж байгаа техник туслалцааны талаар Монгол Улстай ганцаарчилсан уулзалт хийж, Монгол Улсад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр үзүүлсэн болон үзүүлж байгаа техник туслалцааны үр дүнгийн талаар, цаашид нэн шаардлагатай байгаа техник туслалцааны талаар санал бодлоо солилцлоо.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтыг бий болгосон талаар Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх

бүлгийн гишүүн улс орнуудад танилцуулга хийн, сайн туршлага хуваалцсаныг энд цохон тэмдэглэмээр байна. Уг илтгэлд хурлын дарга болон бусад орны төлөөллүүд өндөр сэтгэгдэлтэй байсан.

Ийм үр дүнд хүрэхэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа мэдээж маш чухал үр нөлөөтэй байсан байх?

Тэгэлгүй яахав. Аливаа улсын МУТСТ үйл ажиллагаа нь төрийн болон холбогдох хувийн хэвшлийн хамтын ажиллагаан дээр бүрэн суурилдаг гэж хэлж болно. Манай улсын хувьд ч мөн ялгаагүй МУТСТ Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, хувийн хэвшил идэвхтэй хамтран ажиллаж, дан Зөвлөмж 15-ын хүрээнд ч бус, ФАТФ-ын 40 зөвлөмж, олон улсын стандарт шаардлагуудыг бүрэн хангаж, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхээр ажилладаг. Энэ жилийн уулзалтад Монгол Улсыг төлөөлж Хууль зүй, дотоод хэргийн яамны Б.Солонго Дэд сайдаар ахлуулсан баг оролцсон.

Монгол Улсын 2022 оны Явцын тайланг боловсруулах, үнэлгээний багийн асуултад шаардлагатай нэмэлт тайлбар, мэдээлэл өгөх, жилийн уулзалтаар тайланг хамгаалах үед Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн үнэлгээний баг болон улс орнуудаас тодруулах асуултаудад хариуцах чиг үүргийн хүрээнд хариу, тайлбар өгөх зэргээр идэвхтэй ажилласан.

Үнэлгээ ахиулсан Зөвлөмж 15 буюу виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бий болгох хүрээнд хийсэн ажлуудын талаар тодорхой мэдээлэл өгнө үү.

ФАТФ-ын Зөвлөмж 15-ын дагуу улс орнууд виртуал хөрөнгийн салбарыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хамруулж, зохицуулалтын орчинг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, 2022 оны 02 дугаар сарын 24-

ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлээд байна. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос тухайн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 6 журам шинээр боловсруулж, холбогдох 2 журамд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсан. Мөн холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулж, Монгол Улсын виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. ФАТФ-ын зөвлөмжийн дагуу уг үнэлгээний үр дүнд суурилан, виртуал хөрөнгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Мөн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо 2022 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдээс бүртгэлийн хүсэлт хүлээн авч эхэлсэн.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдлаа. Энэ ямар ач холбогдолтой баримт бичиг вэ?

Монгол Улс МУТСТ тогтолцооны талаар баримтлах бодлогоо Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа 2050-тай нийцтэй байдлаар ФАТФ-ын үндсэн зарчмуудын хүрээнд Дэлхийн банкны техник туслалцаатайгаар хамтран үндэсний хөтөлбөрөө боловсруулан МУЗГ-аар батлуулсан. Уг хөтөлбөр нь 2030 он хүртэл Монгол Улсын МУТСТ тогтолцоонд баримтлах бодлогын чухал баримт бичиг бөгөөд стратегийн үндсэн 8 зорилго, 50 гаруй дэд зорилтуудаас бүрдэнэ. Энэ нь Монгол Улс дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэх, ФАТФ-ын шууд хэрэгжилтийн 11 зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зэрэг өндөр ач холбогдолтой хөтөлбөр юм. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь хавсралтаар ажлын төлөвлөгөөтэй байх юм. Уг ажлын төлөвлөгөөг хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд үндэсний эрсдэлийн үнэлгээ болон бусад баримт бичигт суурилан гаргаж ирсэн.

Ажлын төлөвлөгөөний гол агуулга нь юунд чиглэж байна вэ?

Үндсэндээ 240 орчим ажилтай Үндэсний зөвлөлийн хурлаар батлагдах төлөвлөгөө байгаа юм. Бид үндэсний эрсдэлийн үнэлгээ, харилцан үнэлгээний тайлан, явцын тайлангууд, бусад олон улсын зөвлөмж шаардлагууд, судалгаануудад тулгуурлан гаргаж ирсэн тогтолцооныхоо сул тал, дутагдалтай талуудыг засах ажлууд байгаа юм. Жишээлбэл, салбарын болон байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийдэг тусгай аргачлалтай болох, хүний нөөцөө хөгжүүлэх, бэлтгэх нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, төрийн бүхий л хамаарал бүхий байгууллагуудад мөнгө угаах тогтолцоог хариуцсан нэгж бүтэц эсвэл ажилтанг албан ёсоор бий болгох (одоогоор байхгүй байгууллагуудын хувьд), мөнгө угаахын боловсролыг их дээд сургуулийн түвшингээс эхлэн олгодог, хүний нөөцөө бэлтгэдэг болох, төр хувийн хэвшилд зориулсан сургалтын цахим сан, систем бий болгох, хяналт шалгалтын тогтолцоо, урьдчилан сэргийлэх ажлууд зэрэг олон байгууллагуудын дангаар болон хамтарч хийх ажлуудыг оруулж өгсөн байгаа. Энэ ажлууд төрийн байгууллагуудын түвшинд хэрэгжиж эхэлсэнээр цаашлаад хувийн сектор, мэдээлэх үүрэгтэй этгээдүүдтэй яаж хамтарч ажиллах, ямар байдлаар хүрэх гэдэг нь тодорхой болно.

ФАТФ-ын техник хэрэгжилтийн хангалтгүй үнэлгээтэй байгаа үлдсэн нэг зөвлөмж байгаа. Цаашид энэ үнэлгээг ахиулах, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр ямар ажлууд хийхээр төлөвлөөд байна вэ?

Монгол Улсын хувьд “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байгаа ФАТФ-ын Зөвлөмж 8 буюу ашгийн бус байгууллагын салбарын терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн зохицуулалтын орчинг бүрдүүлэх шаардлагатай байгаа. Үүнтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Холбооны эрх зүйн байдлын тухай болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан. Уг хуулийн төсөл батлагдах, үүнээс гадна Зөвлөмж 8-ын хүрээнд

ашгийн бус байгууллагын салбарт терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгох, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийг холбогдох төрийн байгууллагууд харилцан уялдаатайгаар хэрэгжүүлэх тодорхой шаардлагууд бий. Монгол Улсаас 2023 онд ФАТФ-ын олон улсын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах зорилгоор Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт Явцын тайланг тайлагнаж ажиллах болно.

Монгол Улс зөвхөн гадны үнэлгээчдээр МУТСТ тогтолцоогоо үнэлүүлэхээс гадна өөрсдөө бусад орныг үнэлдэг үнэлгээчин бэлтгэх ёстой. Энэ ч үүднээс олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээчин бэлтгэх нь чухал байгаа. Цар тахлын хоёр жилийн хугацаанд төрийн байгууллагуудаас нийтдээ 9 үнэлгээчнийг бэлтгэлээ. Эдгээр 9 үнэлгээчид маань АНДМУТБ-ээс зөвшөөрвөл бусад улс орны тогтолцоог үнэлэх боломжтой юм. Яг одоо Санхүүгийн мэдээллийн албаны ажилтан маань үнэлгээчний шаардлагад тэнцэн Бүгд Найрамдах Лаос улсын МУТСТ тогтолцоог үнэлэх, харилцан үнэлгээний багт багтан үнэлгээг хийж байна. Салбар бүрт ийм үнэлгээчидтэй болох нь Монгол Улс цаашдаа мөнгө угаах тогтолцоогоо олон улсын түвшинд авч явахад ихээхэн ач холбогдолтой болно.

Ярилцсанд баярлалаа.

ОРГАНИК СЕРТИФИКАТЫН ГАЗРЫН ҮНЭ ЦЭНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

КЕЙТ ФУЛЛЭР* | ЖОЗЕФ ЖАНЗЕН** | Б.МӨНХНАСА***

Хураангуй

Энэхүү судалгаанд органик сертификатын газрын үнэ цэнд, тухайлбал газрын түрээсийн үнэд үзүүлэх нөлөөллийг ердийн газрын үнэ цэнтэй харьцуулан судалсан болно. Нөлөөллийг үнэлэхэд фермийн түвшин дэх тоо мэдээлэл болох газрын түрээс, органик статус, болон газрын эдийн засгийн үр өгөөжийг илтгэх бусад зардал, ашгийн хувьсагчдыг ашиглав. Шинжилгээний үр дүнгээр органик сертификаттай фермийн газрын түрээс нь уламжлалт ердийн тариалангийн газрын түрээсээс 26.0 хувиар өндөр (органик газрын түрээсээс 26.0 хувийн үнийн нэмэгдэл хүртэж) байгааг харуулав.

Удиртгал

АНУ-д органик хүнсний эрэлтийг даган органик сертификаттай буюу органик шошготой¹ фермийн газар тариалан өсч байна. Тухайлбал, 2016 онд 2.7 сая акр² газарт органик сертификаттай үр тариа тариалж байсан нь АНУ-ын нийт тариалангийн талбайн 1.0 хүрэхгүй хувийг бүрдүүлж байв. 2008-2016 онуудад органик тариалангийн талбайн хэмжээ жилийн 2.5 хувиар өсч ирсэн бөгөөд органик үр тариалалт болон органик хүнсний борлуулалт жилийн 10.0 хувиар тус тус өссөн байна (Органик Худалдааны Холбооны тайлан, 2016). Энэхүү органик тариалалтын өсөлтийг харьцангуй өндөр чанартай, үнэ цэнтэй үр тариалах, өндөр ургац, болон бүтээгдэхүүний үнийн нэмэгдэлтэй холбон тайлбарлаж болохоор байна.

* АНУ-ын Монтана Их Сургуулийн ХАА-н Эдийн засгийн тэнхимийн туслах профессор.

** АНУ-ын Иллинойс Их Сургуулийн (Урбана-Шампейн) ХАА-н Эдийн засгийн тэнхимийн туслах профессор.

*** Монголбанкны Судалгаа, статистикийн газрын эдийн засагч

1 Монгол Улсад органик хүнсний эрх зүйн орчин болон түүний баталгаажуулалтыг 2016 оны "Органик хүнсний тухай" хууль, 2018 оны ХХААҮЯ-ны сайдын А/09 тушаалаар батлагдсан багц журмаад зохицуулж байна.

2 1 акр $\approx$ 0.405 гатай тэнцэнэ.



Хэдий органик тариалалт өсч байгаа боловч, нийт органик тариалангийн талбайн хэмжээ органик сертификат авахтай холбоотойгоор хязгаарлагдаж байна. Учир нь органик тариалалтыг эхлүүлэхээс өмнө 3 жил урьдчилан тухайн талбайд аливаа химийн бордоо болон бусад шавьж устгагч бодисыг ашиглахыг хориглодог байна. Ингэснээр органик газрын нийлүүлэлтийг богино хугацаанд хязгаарлаж эластик бус (inelastic) газрын нийлүүлтийн шинж чанартай болгож байна.

Дээр дурьдсан органик сертификатчлалын процесс болон хязгаарлагдмал газрын нийлүүлэлт, органик бүтээгдэхүүний үнийн нэмэгдэл зэрэг хүчин зүйлсүүд органик газрын түрээс буюу тухайн газрын үнэ цэнийг ердийн газрын үнээс илүү өндөрт хүргэж байна.

Органик газрын үнэ цэнийг эмперик судалгааны аргаар үнэлэх нь дараах ач холбогдолтой бөгөөд нэгдүгээрт, органик газар тариалангийн эдийн засгийн үр өгөөжийг судлах, хоёрдугаарт, органик тариалалт руу шилжих болсон үндсэн эдийн засгийн сэдлийг тус тус судлахад юм.

Органик сертификатчлалын газрын үнэ цэнд үзүүлэх нөлөөллийг судлах зорилгоор АНУ-ын ХАА-н яамны Хөдөө аж ахуйн нөөцийн менежментийн (USDA ARMS) 2003 – 2011 он хүртэлх түүвэр судалгаанд хамрагдсан органик болон уламжлалт газар тариалан эрхлэгч фермерүүдийг судлан үзэв. Түүврээс онцлон дурдвал, органик фермийн газрын медиан түрээс ердийн уламжлалт газрын түрээснээс 23.0 хувиар өндөр байв.

Эконометрик загвар, судалгааны үр дүн

Судалгааны гол зорилгонь органик сертификатын газрын үнэ цэнд үзүүлж буй нөлөөллийг газрын түрээсээр жишин эконометрикийн загварын тусламжтайгаар үнэлэхэд оршино. Үүний тулд дараах ердийн хамгийн бага квадратын (ЕХБК) регрессийн загварыг (1) ашиглав. Энэхүү загварын хамаарах хувьсагч r_{ijt} нь j дүүрэг дэх i фермийн t жилд төлсөн газрын түрээсийг илэрхийлж байна.

$$r_{ijt} = \beta_0 + \gamma Org_{ijt} + \varepsilon_{ijt} \quad (1)$$

Загварын гол үл хамаарагч Org_{ijt} хувьсагчийг тэгшитгэл (2) -т зааснаар тайлбарласан бөгөөд энэ нь j дүүрэг дэх i фермийн t жилийн органик талбайг нийт тариалангийн талбайд хуваасан харьцаа үзүүлэлт юм. Онолын үүднээс γ коэффициент нь үл хамаарагч Org_{ijt} хувьсагч буюу тухайн санамсаргүйгээр сонгогдсон органик фермийн хамаарагч r_{ijt} хувьсагч буюу газрын үнэ цэнд үзүүлэх дундаж нөлөөллийг үнэлэж болох байв.

$$Org_{ijt} = \frac{\text{Органик талбай (акр)}}{\text{Нийт талбай (акр)}} \quad (2)$$

Гэвч бодит байдал дээр органик болон энгийн тариалан нь хоорондоо газар зүйн байршил, талбайн хэмжээ, тариаланчийн туршлага, үр тарианы сонголт зэрэг бусад хувьсагчдаас хамааран харилцан адилгүй тул загвар (1) нь орхигдуулсан хувьсагчдын алдаатай байх болно. Иймд загвар (3)-т орхигдуулсан хувьсагчдын алдааг залруулахын тулд хугацаанаас хамраалгүй зөвхөн тухайн фермийн түвшинд хэрэглэгдэж болох орон зайн тогтмол нөлөөг f_j илтгэх хувьсагчдыг X_{ijt} – векторт оруулав.

$$r_{ijt} = \gamma Org_{ijt} + X_{ijt}\beta + f_j + d_t + \varepsilon_{ijt} \quad (3)$$

Хүснэгт 1-т дээрх загвар (3)-т тусгагдсан бусад тайлбарлагч хувьсагчдын X_{ijt} түүврийн хэмжээ, дундаж болон стандарт хазайлт зэрэг мэдээллийг оруулав. USDA ARMS-ын судалгаанаас нийт 37,535 фермийн аж ахуй эрхлэгчдийг түүвэрлэн авсан бөгөөд үүнээс органик талбайтай фермүүд 1,051 буюу нийт түүврийн 2.8 хувийг эзэлж байв. Доорх хүснэгтэд органик болон энгийн фермүүдийн газрын үнэ цэн, тэдний үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц борлуулалтын орлого, хувьсах болон тогтмол зардлууд, ХАА-н тэтгэмж зэрэг хувьсагчдыг оруулав.

Хүснэгт 1. Хувьсагчдын дэлгэрэнгүй мэдээлэл

	Нийт түүвэр		Ердийн тариалан		Органик тариалан		
	Дундаж	Стандарт хазайлт	Дундаж	Стандарт хазайлт	Дундаж	Стандарт хазайлт	
$\$1000/\text{ферм}$							
Борлуулалтын орлого	393	695	388	675	714	1,543	***
Хувьсах зардал	224	420	220	405	487	1,010	***
Тогтмол зардал	73	108	73	106	102	184	***
ROVC	165	369	165	354	184	985	
$\$/\text{акр}$							
Түрээс	112	114	110	108	253	294	***
Түрээслэгдсэн газрын үнэ цэн	4,119	4,576	4,053	4,416	8,934	10,113	***
Борлуулалтын орлого	658	1,307	626	1,193	2,964	4,138	***
Хувьсах зардал	409	887	387	812	2,001	2,749	***
Тогтмол зардал	127	218	124	206	385	617	***

ROVC	251	646	240	592	1,045	2,166	***
Амьтны зардал	6	23	6	23	15	39	*
Даатгал	9	26	9	26	10	32	
Тэтгэмж	19	21	19	21	16	30	
Фермийн бус орлого	362	1,102	352	1,053	1,136	2,906	*
Шилжилтийн төлбөр	1	5	1	5	1	4	*
<i>Бусад хувьсагч</i>							
Үрийн төрөлжилт (Жини коэфф.)	0.91	0.03	0.91	0.03	0.91	0.04	
Өр, активын харьцаа	0.18	1.87	0.18	1.88	0.22	1.34	
Тариалан эрхлэгчдийн нас	52	12.7	52	13	49	12.91	**
Нийт талбай (акр)	995	1,306	996	1,299	972	1,749	
Тариалангийн талбай (акр)	839	1,029	840	1,053	785	1,438	
Түрээсийн харьцаа	0.68	0.36	0.68	0.36	0.66	0.36	
N	37,535		36,484		1,051		

* $p < 0.1$, ** $p < 0.05$, *** $p < 0.01$, ROVC = Орлого-хувьсах зардал

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар анх удаа органик газрын харьцангуй үнэ цэнийг эмперик тооцоо, загвараар үнэлсэн бөгөөд шинжилгээний үр дүнд органик сертификаттай газрын түрээс нь уламжлалт ердийн тариалангийн газрын түрээсээс 26.0 хувиар өндөр байгааг харуулав. Өөрөөр хэлбэл, органик газрын түрээс ердийн газрын түрээсээс акр тутамдаа 29.0

ам.доллараар өндөр байв. Тус тооцоололд органик болон ердийн газрын түрээсийн үнийн зөрүүнд нөлөөлж болохуйц хувьсагчид буюу газар зүйн байршил, газрын үржил шим, үр тарианы сонголт, тариалалтын урсах зардал, тухайн фермер өрхийн орлого зэрэг нөлөөллийг харгалзан үзсэн болно.

Судалгааны бүрэн эх хувийг дараах холбоосоор орж уншина уу:

<http://je.uwpress.org/content/97/1/80.full.pdf+html>



ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ УНГАР УЛСЫН ТУРШЛАГА

Олон нийтийн санхүүгийн боловсролыг улс орнууд бодлогын түвшинд хэрхэн анхаарч үздэг тухай гадны арга туршлагаас энэхүү буландаа онцлохоор зорьж байна. Монголбанк энэ онд Унгарын төв банктai байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд бид тус улс үүнд хэрхэн ач холбогдол өгдөг болохыг сонирхон судалж, энэ чиглэлд харилцан туршлага солилцохоор болсон юм.

Унгар улсын Засгийн газар 2017 онд өрхийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний стратегийг 7 жилийн хугацаатайгаар баталж, хэрэгжилтийн явцад үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёр хоёр жилээр шинэчлэн баталж ажилладаг. Хагас жил тутам холбогдох яамд болон төрийн байгууллагууд болон Мажар Немзети /Төв банк/ банкiйг оролцуулан явцын тайлагналаа олон нийтэд мэдээлдэг байна.

Тус стратеги нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон санхүүгийн боловсролын олон улсын сүлжээний зөвлөмж болон олон улсын шилдэг туршлагыг харгалзан үзэж Унгар улсын иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан боловсруулагджээ. Хэрэгжилтийн хувьд нэгдсэн зохицуулалт дээр суурьладаг бөгөөд төр, мэргэжлийн болон

төрийн бус байгууллагуудын уян хатан хамтын ажиллагаанд тулгуурлан, харилцан мэдлэг солилцдог ажээ. Стратегийн гол зорилтот бүлэг нь сургуулийн насныхан болон багш нар бөгөөд мэдээж насанд хүрэгчдэд хүрэхийг зорьдог, мөн нийгмийн эмзэг бүлгийг орхидуулдаггүй. Стратеги нь зорилтод бүлгүүдэд хүрч ажиллахдаа зохих хэмжээний үр дүн ахиц, дэвшил гаргана гэсэн хүлээлттэй байдаг. Тухайлбал, сургалтын хөтөлбөрт санхүүгийг мэдлэг олгох агуулга багтаах, өрх гэрийн санхүүгийн удирдлагын тогтвортой байдал болон хараат бусаар санхүүгээ удирдах чадварыг бэхжүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим санхүүгийн үйлчилгээг ашиглах, ухаалаг зээл авах гэх зэрэг мэдлэгийг хамруулдаг байна.

СУРГУУЛИЙН НАСНЫХАНД САНХҮҮГИЙН МЭДЛЭГ ОЛГОХ НЬ

Стратегийн гол зорилго нь ирээдүйн иргэд санхүүгийн мэдлэгийг гэр бүл болон амьдралын явцад олж авахаас гадна сургалтын хөтөлбөрөөс сурч мэдэх явдал юм. Санхүүгийн мэдлэгийн агуулгыг хичээлүүдэд хөрвөн суурьшуулах боломжтой бол ерөнхий боловсролын сургуулиар дамжуулан олон олон ирээдүйн иргэдийн санхүүгийн шийдвэр гаргалтыг цэгцтэй, хэмжэгдэхүйц болгох боломж бий.

Сургалтын хөтөлбөр нь амжилттай хэрэгжихийн тулд шийдвэр гаргагчдаас зохих дэмжлэг, магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр, мэргэшсэн багш нарын сургалт, багшийн хангалттай орон тоо, агууллагад шингээх боломжтой хичээлийн тоо болон тухайн хичээлд хандах эцэг эх, сурагчийн хүсэл эрмэлзлийг тооцох нь чухал. Дээрх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд 2008 оноос хойш Унгарт дараах томоохон үр дүн гарсан байна. Үүнд:

- 15 жилийн хүчин чармайлтын үр дүнд өнөөдөр Унгарын хүүхэд болгон ерөнхийн боловсролын сургалтын хөтөлбөлөрөөр дамжуулан олон төрлийн хичээлээс нэгтгэсэн санхүү-эдийн засгийн мэдлэг олгох модульд хамрагддаг.
- Жил бүр 40,000 орчим сурагчид санхүү, эдийн засгийн мэдлэгийг тусгайлан судлах хичээлээс сонгон суралцдаг,
- Нэмэлтээр ангиас гадуурх төрөл бүрийн хөтөлбөрүүдэд хамрагдаж, “Дэлхийн мөнгөний долоо хоног”, Мажар Немзети банкны Мөнгөний музей, түүнчлэн интерактив тэмцээнүүдэд хамрагддаг.

Унгар улсын сургалтын тогтолцоо нь Үндэсний суурь сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурагчид 6-18 нас хүртлээ хамрагддаг. Одоогоор сурагчид 3 төрлийн сувгаар санхүү, эдийн засгийн мэдлэгийг олж авч байна.

- Ерөнхий боловсролын 7-8, 9-10-р ангид (13-16 насныхан) санхүү, эдийн засгийн мэдлэг олгох хичээлийг орон нутгийн сургалтын хөтөлбөрт оруулах боломжтой бөгөөд энэхүү хичээлүүдийг сургуулийн удирдлага өөрийн шийдвэр дээр үндэслэж судлуулах боломжтой. Энэхүү суваг нь сурагчдад илүү гүнзгий мэдлэг олгодог боловч сургууль болгон хамрагдах боломжгүй.
- 2018 оноос эхлэн мэргэжлийн боловсрол олгодог сургуулиудын 10-р ангид (15-16 насны) нэг жилийн хугацаатай заавал судлах “санхүү, гарааны бизнес” хичээлийг нэвтрүүлсэн.
- 2020 оноос эхлэн санхүү, эдийн засгийн модулиудыг үндэсний цөм хөтөлбөрийн нэг хэсэг болгож, заавал судлах хичээлүүдийн нэг болгосон. Агуулга нь математик, газарзүй, түүх, байгалийн ухааны хичээлээр дамжуулан сурагч бүрт хүрдэг боловч үүнийг тусдаа хичээл болгон заахтай харьцуулахад бага үр дүнтэй байдаг.

ЕБС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ САНХҮҮГИЙН МЭДЛЭГ ОЛГОХОД МАЖАР НЕМЗЕТИ БАНК /ТӨВ БАНК/ БОЛОН “МӨНГӨНИЙ ЛУУЖИН” САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Унгар улсын ЕБС-д санхүү, эдийн засгийн хичээл нэвтрүүлэхэд хамгийн чухал мэргэжлийн болон зохицуулах байгууллагуудын нэг бол Мажар Немзети Банкны мэргэжлийн зөвлөх болон санхүүгийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан Мөнгөний луужин сан юм. Энэхүү байгууллага нь инноваци, бодлого, сургалтын хөтөлбөр боловсруулах, багш нарын сургалт, сургуулиас гадуурх болон дижитал сурган хүмүүжүүлэх арга зүй, туршлагад суурилсан дижитал хэрэглүүр боловсруулах зэрэг сэдвийн хүрээнд идэвхтэй ажилладаг.

Мөнгөний луужин сан нь санхүү, эдийн засгийн мэдлэгийг заадаг байгууллагуудыг мэргэжлийн сүлжээ (Сургуулийн мөнгөн сүлжээ)-г үүсгэн байгуулж, одоо 650 идэвхтэй гишүүдээс бүрдэж байна. Тус сан нь дотоодын болон олон улсын шилдэг туршлагыг шийдвэр гаргагчид болон төрийн боловсролын зохицуулалтын байгууллагуудад тогтмол дамжуулж, шинэлэг дижитал хэрэглээг бий болгож, санхүүгийн мэдлэг олгох сэдвээр залуучуудын дунд болон сургуулиудын дунд нээлттэй уралдаануудыг зохион байгуулдаг. Санхүүгийн мэдлэг олгох ажлыг сонирхож буй сурган хүмүүжүүлэгчдийн хувьд заах арга зүйг их дээд сургуулиудаар дамжуулан олгодог. Сургуулиуд тус сангаас боловсруулагдаж, хэвлүүлсэн албан ёсны магадлан итгэмжлэгдсэн сурах бичгийг үнэ төлбөргүй авч, хэрэглэх боломжтой бөгөөд тус сангийн багш бэлтгэх сургалт төлбөргүй байдаг.

НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛСАН САНХҮҮГИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨРҮҮД

Насанд хүрэгчдийн санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Мажар Немзети банк нь "Санхүүгийн хөтөч" мэдээллийн хөтөлбөрийг баталсан бөгөөд хүн амын хамгийн өргөн хүрээг хамарсан олон сувгаар дамжуулан, санхүүгийн шийдвэр гаргах нөхцөл байдал ба өрхийн эдийн засгийн асуудлууд, түүний эрсдэл гэсэн контентуудыг хийдэг.

САНХҮҮГИЙН ХӨТӨЧ ВЭБ КОНТЭНТ

Санхүүгийн анхан шатны мэдлэг, мэдээллээс гадна хэрэгцээт, практик хэрэглээ, тооцоолуур болон богино хэмжээний шторкуудыг "Санхүүгийн хөтөч ба санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах" вэб сайтаас олох боломжтой. Санхүүгийн хөтөч товхимолд өдөр тутмын санхүүгийн талаарх хамгийн их асуудаг дөчин асуултын хариултыг оруулсан байдаг.

ТӨВ БАНКНЫ "САНХҮҮГИЙН ХӨТӨЧ ОФФИС" СҮЛЖЭЭ

2011 онд хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагуудтай хамтран Мажар Немзети банк нь "Санхүүгийн хөтөч оффис" сүлжээг үүсгэн байгуулсан. Зах зээлд оролцогсдод үнэгүй мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилгоор Төв банкны 18 салбарт зөвлөхүүд ажилладаг байна. Уг сүлжээ хөтөлбөрийг Мажар Немзети банк бүрэн санхүүжүүлдэг.

Унгар улсын туршлагаас харахад санхүүгийн мэдлэг болон бизнес эрхлэх соёлыг хөгжүүлэх нь зөвхөн мэдээллийн аян зохион байгуулах замаар хэрэгжих боломжгүйг харуулжээ. Иргэдийг өргөн хүрээнд хамааруулж хандлагын өөрчлөлтөд оруулж байж тодорхой, тогтвортой үр дүнд хүрнэ. Гэсэн хэдий ч хүн амын санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх нь урт хугацааны нөөц шаардлагатай ажил бөгөөд зөвхөн үндэслэлтэй стратегийн зорилтууд, зохих ёсоор боловсруулж уялдуулсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр үр дүнд хүрэх боломжтой. Санхүүгийн мэдлэгийг хөгжүүлэх, үндэсний стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, хөтөлбөрүүдийг уялдуулах, үр дүнтэй хэрэгжүүлэхэд тухайн улсын Төв банкуудын үүрэг чухал ач холбогдолтой ажээ.



*Ирээдүйнхээ төлөө
хуримтлуулъя*